

**BBSA** 



---

**“ГОУЛД ТРАСТ” ХАМТЫН  
БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ  
САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

---

Хаяг: 303 тоот, БиДиСек ХК, Залуучуудын  
өргөн чөлөө 27/1,8-р хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар  
хот Монгол улс

Утас: (+976) 9911-9719

И-мейл: [info@bbsa.mn](mailto:info@bbsa.mn)

Вебсайт: [www.bbsa.mn](http://www.bbsa.mn)

2026-03-24

БҮРТГЭВ-02

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

СЭХ  
2026.03.26 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

Компаний тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн холбогдох журмуудын дагуу “Гоулд траст” хамтын Биржээр арилжаалагддаг санг үүсгэн байгуулж, сангийн нэгж эрхээ олон нийтэд анх удаа санал болгон гаргаж байгаа болно.

Энэхүү нэгж эрхийн танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Хөрөнгө оруулалтын менежментийн компани (цаашид “ХОМК” гэх)-ийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. ХОМК нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

Энэхүү нэгж эрхийн танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Нэгж эрх болоод нэгж эрхэд холбогдох хөрөнгийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд санхүүгийн, хөрөнгө оруулалтын болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдсөний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахыг зөвлөж байна.

**БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САНГИЙН НЭГЖ ЭРХИЙГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ НЭГЖ ЭРХИЙН ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ БОЛОН ТҮҮНИЙ УДИРДАЖ БАЙСАН БУСАД САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭН ГҮЙЦЭТГЭЛ НЬ ЭНЭХҮҮ НЭГЖ ЭРХИЙГ ГАРГАЖ БҮЙ САНГИЙН ИРЭЭДҮЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА БОЛОХГҮЙ. ЭНЭХҮҮ НЭГЖ ЭРХИЙГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА, НЭГЖ ЭРХ ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү нэгж эрхийн танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус нэгж эрхийг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйлс байвал ХОМК болох “Би Би Эс Эй” ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.

2026-03-24

БҮРТГЭВ-02



## Нэгж эрхийн танилцуулгын тухай

Энэхүү нэгж эрхийн танилцуулга нь Гоулд Траст хамтын арилжаалагддаг сан (БАС)-ийн танилцуулга, хөрөнгө оруулалтын тооцоолол, төлөвлөгөө, хамтран ажиллах байгууллагуудын талаар мэдээллийг багтаасан үндсэн бичиг баримт мөн.

## “ГОУЛД ТРАСТ” БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

“Гоулд Траст” биржээр арилжаалагддаг сан нь олон нийтэд нэгж эрхээ санал болгон гаргаж, зах зээлийн үнээр арилжаалагддаг, тасралтгүй горимоор нэмж нэгж эрх гаргах буцаан худалдан авах үүрэг хүлээдэг биржээр арилжаалагддаг сан бөгөөд сан нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулагчдад ам.долларын ханшийн эрсдэлээс хамгаалагдан алтанд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлнэ.

“Гоулд Траст” биржээр арилжаалагддаг сан нь нийт 10 жилийн хугацааны туршид үйл ажиллагаа эрхлэх бөгөөд үйл ажиллагаа дуусгавар болох үед цаашид үйл ажиллагааны хугацааг сунгах эсэх шийдвэрийг гаргах бөгөөд сунгахгүй болсон тохиолдолд өөрийн эзэмшилд буй алт болон бусад эзэмшиж буй хөрөнгийг нэгж эрхэд хувь тэнцүүлэн хуваарилна.

## НЭГЖ ЭРХИЙН МЭДЭЭЛЭЛ

Гоулд Траст БАС нь хөрөнгө оруулагч нарт алтны үнийн хөдөлгөөнөөс богино, урт хугацаанд өгөөж хүртэх боломжийг олгох зорилготой ба уг өгөөжийг хүртээхийн тулд АНУ-ын Нью Йоркын хөрөнгийн биржид бүртгэлтэй SPDR Gold Shares ETF - алтны Биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхэд хөрөнгө оруулалтаа хийнэ. Гоулд Траст БАС-ийн нэгж эрхийн үнэ буюу цэвэр хөрөнгийн үнэлгээ нь 0.01 грамм алттай ижил үнэтэй байна. Сан нь өөрийн нэгж эрхийг Монголын Хөрөнгийн Бирж дээр Үндсэн оролцогчоор дамжуулан тасралтгүй худалдах, буцаан худалдан авах үйл ажиллагааг эрхэлнэ. Хөрөнгө оруулагчид дурын брокерийн компаниар дамжуулан Монголын Хөрөнгийн Биржээс “Гоулд Траст” биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийг худалдан авах боломжтой.

Нэгж эрх гаргагч..... “Гоулд Траст” Хамтын биржээр арилжаалагддаг ХОС

Улсын бүртгэлийн регистр: 6729134

УБ хот, СБД, 8 хороо, Залуучуудын ергэн чөлөө 27/1, БиДиСек ХК-н байр, 303 тоот

Нэгж эрхийн үнэлгээ..... 0.01 грамм алттай дүйцэх төгрөг

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Сангийн нэгж эрхийн танилцуулга

2026-03-24

БҮРТГЭВ-02

BBSA®


Өгөөж болон Эрсдэл..... Алтны үнэ болон ам.долларын ханш

Санал болгох хүрээ..... Олон нийт

Арилжаа Зохион байгуулах бирж..... Монголын Хөрөнгийн Бирж



## НЭГЖ ЭРХ ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ



Үндсэн оролцогч: Би Ди Сек ҮЦК ХК

Хаяг: БиДиСек ХК, Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот Монгол улс

Утас: 976-7555-1919

И-мейл: [info@bdsec.mn](mailto:info@bdsec.mn)

Веб Хуудас: <https://www.bdsec.mn/>

Кастодиан Банк: Хаан Банк ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Монгол улс, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-24, Парк Плейс оффис, 11 давхар, Кастодиан банкны хэлтэс

Утас: +976-7011 1646

И-мейл: [custody@golomtbank.com](mailto:custody@golomtbank.com)

Веб Хуудас: <https://www.golomtbank.com/>

Аудитын компани: “Онч Аудит” ХХК

Хаяг: СБД 2-р хороо, ICC tower, 15 давхар

Утас: +976-99080450

И-мейл: [info@onch.mn](mailto:info@onch.mn)

Веб Хуудас: [www.onch.mn](http://www.onch.mn)

Хуулийн фирм: “Өмгөөллийн зөвлөх партнер” ХХК

Хаяг: СБД, 4-р хороо, , Твин товер, 7 давхар

Утас: 9911 5492, 88137375

И-мейл: [buyna.samdan@yahoo.com](mailto:buyna.samdan@yahoo.com)





Сангийн нэгж эрхийн танилцуулга

**BBSA**



## Агуулга

<b>НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР .....</b>	<b>5</b>
<b>БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САНГИЙН ТУХАЙ .....</b>	<b>6</b>
Биржээр арилжаалагддаг сангийн танилцуулга .....	6
Биржээр арилжаалагддаг сангийн үүсэл хөгжил .....	7
Биржээр арилжаалагддаг сангийн давуу талууд .....	8
Алтан д хөрөнгө оруулдаг ETF -н тухай .....	9
<b>ГОУЛД ТРАСТ БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САНГИЙН ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>10</b>
Танилцуулга .....	10
Удирдлага, Зохион байгуулалт .....	12
Хөрөнгө оруулалтын бодлого .....	14
Цэвэр хөрөнгийн үнэлгээ, нэгж эрхийн үнэ .....	16
Сангийн үйл ажиллагааны хугацаа .....	17
Сангийн зардлын дэлгэрэнгүй .....	17
<b>ГОУЛД ТРАСТ БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>18</b>
Биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийн танилцуулга .....	18
Нэгж эрхийг нийтэд санал болгох шийдвэр .....	19
Нэгж эрх эзэмшигчдийн эрх .....	19
Нэгж эрхийн арилжаа .....	19
Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа .....	21
Биржээр арилжаалагддаг сангийн үйл ажиллагаанд тавих хяналт .....	21
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>23</b>
<b>ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ .....</b>	<b>36</b>
Зах зээлийн эрсдэл .....	36
Үйл ажиллагааны эрсдэл .....	38
<b>ТАТВАР .....</b>	<b>39</b>
Сангийн орлогод ногдох албан татвар .....	39
Хөрөнгө оруулагчийн орлогод ногдох татвар .....	39
<b>ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД .....</b>	<b>39</b>
Үндсэн оролцогч, Брокер .....	39
Кастодиан банк .....	40
Хууль эрхзүйн компани .....	40
Аудит .....	40
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>41</b>
ГОУЛД ТРАСТ БАС-Н ДҮРЭМ .....	41



Сангийн нэгж эрхийн танилцуулга



## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

**“Хөрөнгө оруулалтын сан”** гэж Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.1-т заасны дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар ажиллаж буй нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгийн санг;

**“Биржээр арилжаалагддаг сан”** гэж Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.3-т заасны дагуу үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулалтын санг;

**“Хөрөнгө оруулалтын менежментийн компани”** гэж сантай байгуулсан гэрээний дагуу сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээдийг;

**“Сангийн цэвэр хөрөнгө”** гэж хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хасаад үлдсэн хөрөнгийг;

**“Сангийн зардлын харьцаа”** гэж хөрөнгө оруулалтын санд бусдаас үзүүлэх хөрөнгө итгэмжлэн удирдах, кастодиан, брокер, нягтлан бодох бүртгэлийн зэрэг үйлчилгээний нийт төлбөрийг сангийн цэвэр хөрөнгөд харьцуулсан харьцааг;

**“Хөрөнгө оруулалтын хэрэгсэл”** гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн хуулийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бөгөөд хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогод заасан, хөрөнгө оруулалт хийж болох санхүүгийн хэрэгслийг;

**“Нэгж эрх”** гэж хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалтын санд оруулсан хөрөнгийг өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаасыг;

**“Нэгж эрхийг нийтэд санал болгох”** гэж хөрөнгө оруулалтын сангаас сангийн нэгж эрхийг худалдан авахыг нийтэд санал болгох тогтмол үйл ажиллагааг;

**“Хөрөнгө оруулалтын сангийн гишүүн”** гэж тухайн хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулж сангийн нэгж эрхийг эзэмшигч иргэн, хуулийн этгээдийг;

**“Кастодиан банк”** гэж хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 48-52 дугаар зүйлд зохицуулсан үйл ажиллагаа, үйлчилгээг үзүүлэх кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээдийг;

**“Нэгж эрх эзэмшигчдийн хурал”** гэж биржээр арилжаалагддаг сангийн эрх барих дээд байгууллага байна.

2026-03-24

БҮРТГЭВ-02

БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САНГИЙН ТУХАЙ

BBSA

СЗХ  
2026.03.26 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

### Биржээр арилжаалагддаг сангийн танилцуулга

Хөрөнгийн биржээр нэгж эрх нь чөлөөтэй арилжаалагддаг бөгөөд нэгж эрхээ биржээр дамжуулан худалдах, буцаан худалдан авах үйл ажиллагааг байнга хэрэгжүүлж байдаг хөрөнгө оруулалтын санг Биржээр арилжаалагддаг сан /БАС, Exchange traded fund, ETF/ гэдэг. Чөлөөтэй арилжаалагддаг тул биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийн хөрвөх чадвар өндөр, хөрөнгө оруулалтын ашгаас шимтгэл авдаггүй, татварын үр ашигтай, идэвхгүй удирдлагатай байдаг, хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний шимтгэл, хураамж нь бусад хамтын сангуудыг бодвол бага учир хөрөнгө оруулалт хийхэд хамтын сангаас харьцангуй бага зардалтай байдаг. Investment Company Institute-ийн 2020 оны судалгаагаар ETF нь хамтын сангаас дунджаар 2.7 дахин бага зардалтай тухай үр дүн гарсан байна. Сангийн хөрөнгө оруулагчид нь өөрийн харилцах брокерийн компанидаа зөвхөн арилжааны шимтгэл л төлнө. Хөрөнгө оруулагч нь сангийн эзэмшиж буй суурь хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлэн авах боломжгүй бөгөөд зөвхөн сангийн нэгж эрхийг худалдах, худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх боломжтой байдаг.

Өндөр хөгжилтэй орнуудын хөрөнгийн зах зээлд ETF нь төрөл бүрийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнээр багц бүрдүүлдэг туршлага байдаг. Сан нь нэг буюу хэд хэдэн төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжтой. Олон улсын туршлагаар дараах төрлийн ETF-үүд байдаг.

- Зөвхөн нэг төрлийн үнэт цаасанд хөрөнгө оруулдаг
  - Бондын ETF
  - Таваарын ETF
  - Койны ETF
  - Үнэт металын ETF гэх мэт.
- Салбарын компануудийн үнэт цааснаас багц бүрдүүлдэг
  - Алт олборлох салбарын ETF
  - Санхүүгийн салбарын ETF
  - Цахим спортын салбарын ETF
  - Цахим худалдааны салбарын ETF гэх мэт.
- Бүс нутгийн үнэт цааснаас багц бүрдүүлдэг
  - АНУ-н хувьцааны ETF
  - Европын холбооны хувьцааны ETF
  - БНХАУ-н хувьцааны ETF гэх мэт.
- Индексийн ETF
  - S&P индекст суурилсан ETF Dow Jones индекст суурилсан ETF
  - FTSE 100 индекст суурилсан ETF
  - Түүхий эдийн болон бусад индекст суурилсан ETF гэх мэт.

2026-03-24

БҮРТГЭВ-02




Биржээр арилжаалагддаг сангийн үүсэл хөгжил

1993 онд S&P идекст хөрөнгө оруулалт хийдэг биржээр арилжаалагддаг сан үүсгэн байгуулагдан Америкийн хөрөнгийн бирж (AMEX)-д амжилттайгаар гарч зах зээлд чөлөөтэй арилжаалагдаж эхэлсэн. Түүний дараагаар NASDAQ-100, Dow Jones Industrial Average гэх мэт томоохон индексийн үнэт цааснуудад ижил хувиар хөрөнгө оруулж индексийн гүйцэтгэлтэй ижил биржээр арилжаалагддаг сангууд гарсан. Харин 1998 онд АНУ-д уурхай, мэдээллийн технологи, олон нийтийн сүлжээний гэх мэт эдийн засгийн секторуудын хувьцаанд хөрөнгө оруулдаг сангууд гарсан нь биржээр арилжаалагддаг сангийн хөгжлийг шинэ түвшинд гаргасан бөгөөд 1998 оны сүүл гэхэд АНУ-н эдийн засагт томоохон хэмжээг эзэлдэг салбаруудын хувьцаанд хөрөнгө оруулалт хийдэг сангууд гарсан байна.


2002 оноос эхлэн АНУ-н засгийн газрын бондод хөрөнгө оруулалт хийдэг сангууд гарсан бөгөөд цаашид валют, таваарууд гэх мэт төрөл бүрийн биржээр арилжаалагддаг сангууд зах зээлд гарч олон нийтэд санал болгон арилжаалагдаж эхэлсэн.

Биржээр арилжаалагддаг сангийн зардал багатай, хөрвөх чадвар өндөртэй, татварын үр ашигтай гэх мэт давуу талууд нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж байгаа бөгөөд сүүлийн 16 жилийн хугацаанд олон улсын санхүүгийн зах зээлд БАС-гуудад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ тогтмол өсөж байна. Тухайлбал, PWC олон улсын аудит, хөрөнгийн үнэлгээний компаний судалгаагаар хойд Америкийн БАС-гууд жилд дунджаар 23 хувийн өсөлтийг үзүүлж байна.

График 1 Дэлхийн нийт ETF-н хөрөнгийн хэмжээ /их наяд ам.доллар/



Source: Morningstar Direct, as of December 31, 2024. Characteristics are as of the date indicated, are subject to change, and should not be relied upon as current thereafter. **Past performance is not a reliable indicator of future performance.**



(J.P Morgan Asset Management, 2020)

#### Биржээр арилжаалагддаг сангийн давуу талууд

ETF сангийн давуу тал нь хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулагчдад үүсдэг бэрхшээлүүдийг арилгаж бага зардалтайгаар багцын хөрөнгө оруулалт хийх боломжийг олгодог. Сан нь ихэвчлэн идэвхгүй хэлбэрийн удирдлагатай байдаг тул шууд хөрөнгө оруулалт хийх болон бусад хамтын сангаас илүү хямд өртөгтэй байдаг.


#### ETF сангийн давуу тал

- Олон хувьцааны багц, санхүүгийн хэрэгслүүдийг нэг арилжаагаар авах эсхүл зарах боломжтой.
- Бага зардалтай бөгөөд брокерийн шимтгэл багатай.
- Диверсификаци нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх боломжийг олгодог.

#### ETF сангийн сул тал

- Идэвхтэй удирдлагатай ETF нь өндөр зардалтай байдаг.
- Суурь хөрөнгө арилжаалагдаж буй зах зээлд хөрвөх чадвар багатай үед төлбөр тооцооны гүйлгээ удааширдаг.

График 3 ETF санд хөрөнгө оруулагчийн ETF-с өмнөх хөрөнгө оруулалт



#### Алтанд хөрөнгө оруулдаг ETF -н тухай


Алтны ETF нь хөрөнгө оруулагчдад сангаар дамжуулан алтны үнийн хөдөлгөөнөөс өгөөж хүртэх боломжийг бий болгодог. Алтны ETF нь биет алт худалдан авахад үүсдэг нэмэгдэл зардалгүйгээр алтанд хөрөнгө оруулалт хийх хялбар бөгөөд үр дүнтэй арга, хэлбэр болсоор иржээ. Жишээлбэл биет алт нь хулгайлагдах эрсдэлтэй, бага дүнгээр худалдан авах боломжгүй, харуул хамгаалалтын зардал, даатгалын зардал өндөр гарах гэх мэт хүндрэлүүдтэй байдаг нь хөрөнгө оруулагчдийг алтанд хөрөнгө оруулалт хийхэд хүндрэл учруулдаг. Алтны ETF нь алттай ижил үнийн хөдөлгөөнтэй бөгөөд дээрх бусад эрсдэлийг хөрөнгө оруулалтын менежментийн компани хариуцдаг учир хялбар бөгөөд хямд зардалтайгаар алтанд хөрөнгө оруулах боломжийг бий болгодог.

Хөрөнгө оруулагч нь биржээс хувьцаа авч байгаатай адилаар биржээс Алтны ETF-н нэгж эрхийг худалдан авах боломжтой. Хөрөнгө оруулалтын менежментийн компани болон үндсэн оролцогчид нь олон улсын зах зээлд алтанд хөрөнгө оруулалт хийн нэгж эрхийн үнэлгээг алттай ижил байх нөхцөлийг бүрдүүлдэг учир нэгж эрхийн үнэлгээ нь алтны үнэтэй байнга ижил түвшинд байдаг.

Алтны ETF-ийн зах зээл нь сүүлийн жилүүдэд өндөр өсөлттэй байгаа бөгөөд Дэлхийн алтны зөвлөл (World Gold Council)-ийн судалгаагаар алтны ETF-үүдийн нийт хөрөнгө оруулалт 2025 онд нийт 4,000 тонн алт болж, өмнөх оноос 677 тн алтаар нэмэгдсэн байна.

## Gold ETFs holdings

Monthly holdings in Tonnes



Data as of 30 November 2025

Sources: Bloomberg, Company Filings, ICE Benchmark Administration, World Gold Council; Disclaimer: <https://www.gold.org/terms-and-conditions#proprietary>  
See methodology note: <https://www.gold.org/downloads/file/16223/ETF-Flows-Data-Methodology.pdf>

GOLDHUB.COM WORLD GOLD COUNCIL

## ГОУЛД ТРАСТ БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

### Танилцуулга

Голд Траст биржээр арилжаалагддаг сангийн үндсэн зорилго нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн дээр сангийн хөрөнгийг алтанд хөрөнгө оруулдаг SPDR Gold Shares ETF-т оруулах замаар алтны үнийн хөдөлгөөний өгөөж болон эрсдэлийг нэгж эрх эзэмшигчдэд хүртээхэд чиглэнэ.

Сангийн нэгж эрх нь алтанд хөрөнгө оруулахтай ижил бөгөөд сан нь идэвхгүй удирдлагатай учир **зөвхөн** нэгж эрхэд харгалзах алтны Биржээр арилжаалагддаг санд хөрөнгө оруулалт хийнэ.

Сангийн хөрөнгө оруулалт хийх үндсэн хэрэгсэл нь Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг алтны биржээр арилжаалагддаг сан болох SPDR Gold Shares юм. Уг биржээр арилжаалагддаг сан нь алтны үнэтэй зэрэг хөдөлдөг, зардал багатай, үр ашигтай хөрөнгө оруулалтын хэлбэр юм. (цаашид алт гэнэ)

Сангийн хөрөнгийн бүтцэд зөвхөн алт байдаг бөгөөд сангийн эзэмшиж буй биет алт нь London болон New York хотууд дах кастодиан банк болох JP Morgan, HSBC-ын алтны сейфэнд хадгалагддаг. Уг сангийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авч болно.

[www.spdrgoldshares.com](http://www.spdrgoldshares.com)

Сан нь нэгж эрхээ тасралтгүй горимоор буцаан худалдан авах үүрэгтэй учир нэгж эрх худалдан авах тухай бүрт нэгж эрх эзэмшигчийн мөнгийг өгөх

зорилгоор сул чөлөөт мөнгөн хөрөнгө нь банкаар шилжих, эсвэл Санхүүгийн Зохицуулах Хорооноос журамлан зөвшөөрсөн тохиолдолд банкнаас зээл авах байдлаар сангийн хөрөнгөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байж болно.

Сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа дээр дурдагдсан санхүүгийн хэрэгслүүдээр хязгаарлагдах бөгөөд өөр хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийхгүй.

Сангийн нэгж эрхийн үнэлгээ нь 0.01 грам алтны олон улсын зах зээл дээрх үнийг даган хөдлөх бөгөөд ижил төстэй бүтээгдэхүүн болох биет алтны хөрөнгө оруулалтаас харьцангуй бага зардалтайгаар алтанд хөрөнгө оруулалт хийх боломжтой. Сангийн нэгж эрхийн үнэлгээ нь цэвэр хөрөнгөөр тооцогдох тул сангийн үйл ажиллагаатай холбогдох зардлууд нь нэгж эрхийн үнэлгээнд тусгагдсан байна.

Сан нь нэгж эрхээ Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэйгээр арилжаалах бөгөөд сангийн үндсэн оролцогчоор дамжуулан нэгж эрхээ худалдах, буцаан худалдах үйл ажиллагааг **ТОГТМОЛ** явуулах үүрэг хүлээнэ.

#### СВОТ шинжилгээ

##### Давуу талууд

- Сан нь дотоодын хөрөнгө оруулагчид олон улсын зах зээлд хөрөнгө оруулалт хийх боломжийг олгож байгаа нь олон улсын зах зээлд алтны ханшийн өсөлтөөс өгөөж олохоос гадна, төгрөгтэй харьцах ам.долларын ханшийн хөдөлгөөнөөс өгөөж олох буюу төгрөгийн ханш сулрах эрсдэлээс хамгаалагдах боломжтой юм.
- Хөрөнгө оруулагч нь Сангийн нэгж эрхийг худалдан авах, буцаан худалдах арилжааг хөрөнгийн биржээр дамжуулан хийх бөгөөд сан нь үндсэн оролцогчоор дамжуулан өөрийн нэгж эрхийг зах зээлийн үнэлгээгээр худалдан авах үүрэгтэй. Иймд сангийн нэгж эрх нь өндөр хөрвөх чадвартай буюу хэзээд борлуулагдах боломжтой бүтээгдэхүүн юм.
- Алтанд бага хэмжээгээр буюу 0.01 грамм алттай тэнцэх хэмжээгээр хөрөнгө оруулалт хийх боломж олгоно.
- Зохицуулалт, хяналттай зах зээлд арилжаалагдах тул найдвартай байдлыг нэмэгдүүлнэ.
- Хөрөнгө оруулалтын сагс үүсгэх болон урт хугацааны үнэ цэнээ алдахгүй хөрөнгө оруулалт хийх боломжийг олгоно.

##### Сул тал

Алтны ханш нь ажлын 5 өдөрт 24 цагаар арилжаалагддаг боловч Монголын хөрөнгийн биржийн арилжааны цаг богино байгаа бөгөөд Дэлхийн томоохон зах зээлүүд болох АНУ ба Европын улсуудын хөрөнгийн захын арилжааны цагт алтны ханшийн савалгаа харьцангуй өндөр байдаг.

2020-03-24

БҮРТГЭВ-02

Сангийн нэгж эрхийн танилцуулга

BBSA

СЭХ

2020-03-26 өдөр

БҮРТГЭВ

31-01

Иймд алтанд хөрөнгө оруулдаг биржээр арилжаалагддаг санд богино хугацааны хөрөнгө оруулалт хийхээс урт хугацаанд алтанд хөрөнгө оруулалт хийх нь илүү үр дүнтэй байдаг.

### Боломж

- Монголын зах зээлд шинэ бүтээгдэхүүнтэй холбоотой тухайн бүтээгдэхүүний онцлогийг шингээсэн дүрэм, журам батлагдах нь зах зээлд арилжаалагдахад илүү хялбар болох боломжтой.
- Биржийн арилжааны хэмжээ өсч байгаагаас хамаарч арилжааны шимтгэлийн хувь буурах боломжтой.


### Эрсдэл

- Гадаад валютын арилжаанд хомсдол үүсэх, гадаад төлбөр тооцоо удаашрах нь сангийн нэгж эрхийг буцаан худалдсан хөрөнгө оруулагчдын төлбөрийг хийхэд цаг алдах магадлал үүсдэг.

### Удирдлага, Зохион байгуулалт

Гоулд Траст биржээр арилжаалагддаг сангийн хөрөнгийг зөв зохистой удирдан, хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулж, удирдах үйл ажиллагааг эрхлэхэд мэргэжлийн туршлагатай, мэргэжлийн ёс зүйг эрхэм болгосон баг хамт олон, зохистой засаглалаар ажиллана.

Схем 1 Удирдлага, Зохион байгуулалтын бүтэц



Сангийн дээд эрх, удирдлагыг Нэгж эрх эзэмшигчдийн хурал хэрэгжүүлэх бөгөөд хурлын эзгүйд хурлаас томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөл ажиллана. Сангийн дүрмийг энэхүү танилцуулгын Хавсралтанд байршуулсан болно.

Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн анхны хурал болтол ажиллах Төлөөн удирдах зөвлөлийн гишүүд:

**ТУЗ-н дарга Г.Төмөрхуяг**

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн байдал:

- 1986 онд ЗХУ, Москва, Олон Улсын Харилцааны Дээд Сургууль, гадаад худалдааны эдийн засагч

**ТУЗ-н гишүүн Ш.Энхтөр**

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн байдал:

- 1997 онд МУИС, Эрх зүйч
- 2004 онд СЭЗДС, банкны удирдлага

**ТУЗ-н гишүүн Л.Ишжамц**

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн байдал:

- 1994 онд ЦСДС, эрх зүйч
- 2007 онд СЭЗДС, банкны эдийн засагч
- 2009 онд МУИС, хууль, магистр

**Удирдлагын баг**

Компаний удирдлага болон нийт багийн гишүүд нь банк санхүү, менежментийн чиглэлээр мэргэшсэн, бие биенээ орлох чадвартай, ажил мэргэжлийн дадлага туршлагатай баг хамт олон ажиллана.

Компаний дотоод журмаар үүрэг хариуцлага, ажилтан бүрийн эрх мэдэл, ажил үүрэг, удирдлагын бүтэц тогтолцооны дагуу харилцаа зэргийг тусгаж, ажилтан нэг бүр ажил үүргийн хуваарь, харилцагчийн болон компаний дотоод мэдээллийн нууцлалыг бүрэн ханган ажиллана.

**Хөрөнгө оруулалтын зөвлөх Ж.Батаа**

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн байдал:

- 1999-2000 онд University of Birmingham, England MBA

Ажлын туршлага:

- 1996-2000 Монгол Шуудан банканд дилер, ахлах дилер
- 2001-2008 Худалдаа хөгжлийн банк, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал
- 2008-2010 Кредит Монгол ББСБ, Гүйцэтгэх захирал
- 2010-2017 Монголбанк, Санхүүгийн зах зээлийн Газрын захирал, хэлтсийн захирал
- 2017-2020 Тээвэр хөгжлийн банк, Гүйцэтгэх захирлын орлогч
- 2021-2024 Хөгжлийн банк Тэргүүн дэд захирал, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
- 2025 - БиБиЭсЭй ХХК ТУЗ-н дарга, хөрөнгө оруулалтын менежер

**Сангийн менежер С.Батсайхан**

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн байдал:

- Хүмүүнлэгийн ухааны их сургууль Англи хэлний бакалавр
- 2019 онд МУИС Бизнесийн сургуулийг Банк, Санхүү мэргэжлээр бакалавр
- 2020 оноос МУИС Бизнесийн сургуульд Магистрант

Ажлын туршлага:

- 2019-2021 онд Тээвэр Хөгжлийн Банкны хөрөнгө зохицуулалтын дилер мэргэжлээр ажилласан.

**Хөрөнгө оруулалтын бодлого**

Сангийн хөрөнгө оруулалтын зорилт нь Монголын хөрөнгө оруулагч, алтны үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд, банкны хадгаламж эзэмшигчид, ялангуяа ам долларын хадгаламж эзэмшигчдэд хөрөнгө оруулан өгөөж хүртэх, арилжаа хийж ашиг олох, ханшийн эрсдэлээс хамгаалагдах боломжийг олгох юм.

Сангийн нэгж эрх нь алтанд хөрөнгө оруулахтай ижил үр дүн авчрах бөгөөд сан нь идэвхгүй удирдлагатай учир зөвхөн нэгж эрхэд харгалзах алтны хөрөнгө оруулалтыг хийх бөгөөд сул чөлөөт, төлбөр тооцоо хийж буй мөнгөн хөрөнгийг банканд байршуулна.

Сан нь олон улсын зах зээл дээр чөлөөтэй, идэвхтэй арилжаалагддаг алтыг хөрөнгө оруулагчдад санал болгох бөгөөд Хөрөнгө оруулалтын нийт нэгж эрхийн үнэлгээний дүнтэй 100 хувь ижил дүнтэйгээр алтанд хөрөнгө оруулалт хийнэ.

Сангийн хөрөнгийн найдвартай байдлыг байнга хангах, гадаад дотоодын зах зээл, харилцагч санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг байнга судална.

- Санд зөвшөөрөгдөх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд дараах хөрөнгө оруулалтын хэрэгслүүд хамаарна. Үүнд:
  - Алтны АНУ-ын Нью Иоркын хөрөнгийн биржид бүртгэлтэй SPDR Gold Shares ETF-н нэгж эрх
  - Гадаадын болон үндэсний валют;
  -
- Санд хязгаарлалт бүхий зөвшөөрөгдөх дараах хөрөнгө оруулалтын болон санхүүгийн хэрэгслүүд хамаарна. Үүнд:
  - ТТГЧ-ыг хангах зорилгоор банкнаас авах зээл (Санхүүгийн зохицуулах хорооноос журамлан, зөвшөөрсөн тохиолдолд ашиглана.)
  - Алт болон валютын үүсмэл санхүүгийн хэрэгсэл (Санхүүгийн зохицуулах хорооноос журамлан, зөвшөөрсөн тохиолдолд ашиглана.);

Сангийн хязгаарлалт бүхий хэрэгслүүдийг тайлбарлавал:

Зээл: “Гоулд Траст” биржээр арилжаалагддаг сан нь олон нийтэд нэгж эрхээ гаргах, гаргасан нэгж эрхээ буцаан худалдан авах үүрэг хүлээдэг биржээр арилжаалагддаг сан юм. Сан нь хөрөнгө оруулагчид нэгж эрхийн төлбөрт мөнгөн хөрөнгө олгохдоо өөрт буй сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ашиглах бөгөөд сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөний төлбөр тооцоо саатсан тохиолдолд банкнаас богино хугацаатай зээл авч болно. Энэхүү зээлийг нь нэгж эрхэд харгалзах хөрөнгө оруулалтыг буцаан худалдсаны төлбрийг хүлээн авах хүртэл хугацаанд авах бөгөөд төлбөр хүлээн авсан даруйд буцаан төлнө.

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл: Сангийн худалдсан, буцаан худалдан авсан нэгж эрхийн арилжаа болон төлбөр тооцоо хийх хоорондох цаг хугацааны зөрүү болон төлбөр тооцоо саатахаас үүдэн зах зээл дээр алтны үнэ, валютын ханшны зөрүү үүсэх эрсдлээс хамгаалан зөвхөн хедж хийх зорилгоор ашиглагдана.

**Сангийн үр өгөөжийн талаарх төсөөлөл**

Сангийн хөрөнгө оруулах хэрэгслийн сүүлийн 10 жилийн түүхэн тоо мэдээлэл болон холбогдох судалгаанууд дээр үндэслэн тооцоолсон таамаглал,

АЛТНЫ ҮНЭ								
	алтны үнэ	%	GLD	%	USDMNT	%	Голд Траст	%
2014	1,222.00		113.58		1,883.00		739.80	
2015	1,068.00	(12.60)	101.46	(10.67)	1,995.00	5.95	685.02	(7.40)
2016	1,151.00	7.77	109.61	8.03	2,482.00	24.41	918.48	34.08
2017	1,261.00	9.56	123.65	12.81	2,433.00	(1.97)	986.39	7.39
2018	1,247.00	(1.11)	121.25	(1.94)	2,637.00	8.38	1,057.23	7.18
2019	1,476.00	18.36	142.90	17.86	2,727.00	3.41	1,294.08	22.40
2020	1,856.00	25.75	178.36	24.81	2,849.00	4.47	1,700.05	31.37
2021	1,786.00	(3.77)	170.96	(4.15)	2,848.00	(0.04)	1,635.36	(3.81)
2022	1,796.00	0.56	169.64	(0.77)	3,431.00	20.47	1,981.15	21.15
2023	2,029.00	12.97	191.17	12.69	3,421.00	(0.29)	2,231.65	12.64
2024	2,644.00	30.31	242.13	26.66	3,417.00	(0.12)	2,904.67	30.16
2025	3,650.00	27.23	318.07	31.36	3,600.00	5.36	4,224.61	45.44
2026	3,761.00	11.80	327.74	3.04	3,834.00	6.50	4,636.03	9.74
2027	3,894.00	3.54	339.33	3.54	4,083.21	6.50	5,111.98	10.27
2028	4,046.00	3.90	352.58	3.90	4,348.62	6.50	5,656.77	10.66
Дундаж		9.59		9.08		6.47		16.52
Тайлбар:	1	2014-2025 оны 9 сар хүртэлх тоо нь бодит түүхэн дата						
	2	2026-2028 оны алтны үнийн таамаглалыг Bloomberg-н судалгаанаас авсан						
	3	2026-2028 оны ам долларын төгрөгийн эсрэг таамаглалыг сүүлийн 10 жилийн дундаж өөрчлөлтөөр тооцсон						
	4	Голд Траст Хамтын ХОС-н нэгж эрхийн үнийг бусад үнэ ханшаас тооцсон						

Голд траст нэгж эрхэд хөрөнгө оруулснаар дээрх өгөөжийг хүртэхийн хажуугаар ам доллар төгрөгийн ханшийн эрсдлээс хамгаалах, ханшийн есөлтөөс өгөөж хүртэх боломжтой юм.

#### Цэвэр хөрөнгийн үнэлгээ, нэгж эрхийн үнэ


Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг тооцохдоо сангийн хөрөнгийн нийт дүнгээс сангийн нийт өр төлбөр, зардлыг хасч тооцно. Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ нь алтны төгрөгт шилжүүлсэн үнэтэй ойролцоо байна. Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг Кастодиан банк хараат бусаар тооцоолон өдөр бүрийн биржийн арилжааны цагын дараа зарлах бөгөөд Хөрөнгө оруулалтын менежментийн компани өөрсдөө болон хөрөнгийн биржийн веб хуудсаар олон нийтэд зарлана.

Сангийн нэгж эрхийн үнийг доорх байдлаар тодорхойлно:

#### НЭГЖ ЭРХИЙН ҮНЭ

$$= \left( \frac{\text{Алт авах ханш} * \text{Ам. доллар авах}}{3110.34768} + \frac{\text{Алт зарах ханш} * \text{Ам. доллар зарах}}{3110.34768} \right) / 2$$

Нэгж эрхийн үнэ тодорхойлохдоо олон улсын хөрөнгийн зах зээл дээрх алтны ам.долларын эсрэг харьцах авах болон зарах ханшийг ам.долларын эсрэг төгрөгийн авах болон зарах ханштай тус тус харьцуулана.



Нэгж эрхийн үнэд үндэслэн нэгж эрхийг зарах (нэгж эрхийн үнээс их байна), буцаан худалдан авах (нэгж эрхийн үнээс бага) ханшийг Үндсэн оролцогч биржээр дамжуулан хөрөнгө оруулагчдад байнга санал болгоно.

Нэгж эрхийг зарах, буцаан худалдан авах ханшийн зөрүүний дээд хязгаарыг Сан тухайн үеийн олон улсын зах зээл дээрх алтны ханшийн хэлбэлзэл, төгрөг болон ам.долларын ханшийн хэлбэлзэл, гадаад, дотоод зах зээлийн хөрвөх чадвар зэргээс хамааруулан тогтоох бөгөөд зах зээл дээр онцгой савалгаа үүсэхээс бусад тохиолдолд нэгж эрхийн үнийн 2 хувиас хэтрэхгүй.

#### Сангийн үйл ажиллагааны хугацаа

Сан нь 10 жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлэх бөгөөд хугацааны эцэст Нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хугацааг дахин сунгаж болно.

#### Сангийн зардлын дэлгэрэнгүй

Сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдох дараах зардлууд гарна. (харилцагч сангийн нэгж эрхийг худалдан авч 1 жилийн хугацаанд эзэмшиж байсан тохиолдолд)

ЗАРДЛЫН ТӨРЛҮҮД	ХУВЬ
МЕНЕЖМЕНТИЙН ЗАРДАЛ	2.80%
КАСТОИАНЫ ТӨЛБӨР	0.20%
ГАДААД АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАРДАЛ	0.60%
ДОТООД АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАРДАЛ	0.50%
GLD ШИМТГЭЛ	0.40%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.80%
<b>НИЙТ ЗАРДЛЫН ХАРЬЦАА</b>	<b>5.30%</b>

Сангийн зардлууд нь нэгж эрх эзэмшигчээс нэмж төлөгдөхгүй бөгөөд тус зардлуудыг хуримтлуулан тооцож нийт сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээнд тооцогдоно.

Сангийн зардлуудыг өдөр бүр хуримтлуулан тооцож нэгж эрхийн үнэлгээг тооцоход ашиглана. Нэгж эрхэд 1 өдөр хөрөнгө оруулсан тохиолдолд сангийн зардал нь таны хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн 0.0145 хувь байна.

2026-03-24

БҮРТГЭВ-02

Сангийн нэгж эрхийн танилцуулга

BBSA®

\*Сангийн зардлын хувь нь сангийн нийт хөрөнгө, нэгж эрхийн арилжааны эргэцтэй шууд холбоотой, арилжаа хийх болгонд гардаг зардлуудаас ихээхэн хамааралтай.

\*\*Сангийн үйл ажиллагааны зардлуудад хуулийн дагуу зайлшгүй байх ёстой аудитын зардал, сангийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэхэд зориулсан маркетингийн үйл ажиллагааны зардал гэх мэт үйл ажиллагааны зардлууд туссан. Тогтмол зардлууд сангийн хөрөнгө өсөх тусам нэг нэгж эрх эзэмшигчид ногдох хэмжээ буурна.

\*\*\*Санг үүсгэн байгуулахтай холбоотой Зохицуулагч байгууллага, арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжын байгууллагын хураамж, шимтгэл, хуулийн зөвөлгөө, үнэт цаасны танилцуулга бэлдэх, олон нийтэд суртчилан танилцуулах зэрэг зардлуудыг сангийн үйл ажиллагаа явуулах 10 жилийн турш өдөр бүр ижил дүнгээр хорогдуулан ХОМК-д төлнө.

#### Татвар

Сан нь тусгай зориулалтын компани хэлбэртэй хуулийн этгээд бөгөөд татвар төлөгч аж ахуй нэгж юм. Сангийн өдөр бүрийн үйл ажиллагаанаас үүсэх зардал болон хөрөнгө оруулагчийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаарч сан нь зардалтай ажиллах бөгөөд сангийн хөрөнгө оруулалтын өгөөж нь татвар ногдохгүй орлого байхаар хүлээгдэж байгаа тул орлогын албан татварт ногдох ашигт ажиллагаагүй байна. Иймд хөрөнгө оруулагчийн өгөөжид давхар татвар тооцогдохгүй буюу алтны үнийн өсөлтөөс үүдэх орлогод сангийн зүгээс татвар ногдуулан тооцохгүй.

Хөрөнгө оруулагч нь өөрийн арилжааны орлогод ногдох ХХОАТатвар эсхүл ААНОАТатварыг татварын хууль тогтоомжийн дагуу хариуцан төлнө. Сан нь хөрөнгө оруулагчийн өгөөжид татвар суутгагчийн үүрэг гүйцэтгээгүй болно.

### ГОУЛД ТРАСТ БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

#### Биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийн танилцуулга

“Гоулд Траст” Биржээр арилжаалагддаг сан нь нэг бүр нь 0.01 грамм алттай тэнцэх үнэ бүхий нийт 50 сая нэгж эрхийг зарлаж, олон нийтэд тогмол санал болгон арилжаална. Хөрөнгө оруулагч нь үнэт цаасны брокерийн компаниар дамжуулан Монголын хөрөнгийн биржээс сангийн нэгж эрхийг худалдан авах боломжтой.

Сангийн нэгж эрхүүд нь бүгд ижил бөгөөд сангийн эзэмшлийг тодорхойлно. Нэгж эрх бүр шилжүүлэгдэх, арилжаалагдах, санд буцаан худалдагдах боломжтой. Сан нь нэгж эрх эзэмшигчдэд алтны үнийн хөдөлгөөний өгөөж болон эрсдэлийг хүртээх зорилготой. Иймд хөрөнгө оруулагч нь алтны ханшийн өөрчлөлтөөс өгөөж хүртэх боломжтой ба сан нь ирээдүйд аливаа ногдол ашиг хүлээн авахгүй ба хувиарлахгүй.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг үндэслэн 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдөр Би Би Эс Эй компанийн Хувь нийлүүлэгчдийн хурлын №2021/1 дугаар бүхий шийдвэрээр “Гоулд Траст” биржээр арилжаалагддаг санг үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн хүрээнд 2025 оны 03 сарын 18-ны өдөр сангийн нэгж эрхийг нийтэд санал болгон арилжаалахаар шийдвэрлэсэн. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 12 сарын 11-ний өдрийн хурлаар “Гоулд Траст” хамтын Биржээр арилжаалагдах санг бүртгэж авах тогтоол гарсан. Хавсралтаар сангийн дүрмийг оруулав. Хөрөнгө оруулагч та санд хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахаас өмнө сангийн дүрэмтэй сайтар танилцаж шийдвэрээ гаргана уу.

### Нэгж эрх эзэмшигчдийн эрх

Сангийн нэгж эрх эзэмшигч нь дараах эрхтэй байна:

- Өөрийн эзэмшиж буй нэгж эрхээ иргэний хуульд заасан зохицуулалтын хүрээнд захиран зарцуулах /худалдах, бэлэглэх, барьцаалах, өв залгамжлуулах, болон хуулиар зөвшөөрсөн бусад хэлбэр/
- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд нэгж эрх тус бүрээр саналын эрхтэй оролцох;
- Хөрөнгө оруулалтын сангийн талаарх холбогдох мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах
- Санг татан буугдсан тохиолдолд өөрт ногдох хөрөнгийг хүлээн авах

### Нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулагч нь сангийн нэгж эрхийг худалдах худалдан авах арилжаанд дараах дарааллаар оролцно.



#### Брокерийн компанид данс нээх

- Хөрөнгө оруулагч нь өөрийн харилцагч брокерийн компанид хандан үнэт цаасны болон төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны дансаа нээлгэнэ. Брокер тус бүрийн үйлчилгээний шимтгэл хүраамж, зайнаас арилжаанд орох боломж зэрэг нь харилцан адилгүй байдаг тул брокерийг сонгохдоо үйлчилгээний нөхцөлийг харьцуулан судлах хэрэгтэй.

#### Хөрөнгө байршуулах

- Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкин дахь өөрийн дансандаа худалдан авах нэгж эрхийн үнэ болон шимтгэлийн төлбөрийг байршуулж, брокерийн компанидаа үнэт цаас худалдаж авах захиалгаа өгнө.

#### Худалдан авах захиалга өгөх,

- Хөрөнгө оруулагчийн захиалгатай ханш болон тоо хэмжээний хувьд нийцэх захиалга, эсхүл сангийн санал болгож буй ханштай нийцэж байвал захиалга биелэгдэж хэлцэл хийгдэх ба нийцэх захиалга байхгүй тохиолдолд захиалгын санд хадгалагдаж биелэгдэх хүртэл тодорхой хугацаанд хүлээнэ.

#### Худалдах, захиалга өгөх

- Сангийн нэгж эрхийг буцаан худалдах үед хөрөнгө оруулагч нь нэгж эрхийг худалдах ханш болон дүнг брокерийн компаниар дамжуулан худалдах захиалга өгөх бөгөөд биржид байгаа худалдан авах захиалгатай нийцэж байвал захиалга биелэгдэж хэлцэл хийгднэ.

### Үнэт цаасны данс

Нэгж эрхийн арилжаа нь Монголын Хөрөнгийн Биржээр хийгдэх бөгөөд хөрөнгө оруулагч нь үнэт цаасны арилжаанд оролцохын тулд өөрийн харилцагч үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэсэн байх шаардлагатай. Үнэт цаасны данс нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон сангийн хөрөнгийн хадгалалтыг хариуцан ажиллах Хаан Банкны кастодиан банкны бүртгэлд найдвартай хадгалагдах юм. Хөрөнгө оруулагч та данс нээх талаар дэлгэрэнгүй мэдээллийг брокерийн үйл ажиллагаа эрхэлдэг үнэт цаасны компаниас тодруулах боломжтой.

### Нэгж эрхийн үнэлгээ, захиалга

Сангийн нэгж эрх нь 0.01 грамм алтны төгрөгөөр илэрхийлэгдсэн үнэтэй жишиг үнэ байх бөгөөд Монголын хөрөнгийн биржийн арилжааны цагаар тогтмол шинэчлэгдэж, арилжааны захиалга тогтмол хийгдэж байна. Хөрөнгө оруулагчид нь нэгж эрхийг худалдан авах захиалгыг өөрийн харилцагч үнэт цаасны компаниар дамжуулан Монголын Хөрөнгийн Биржид оруулах бөгөөд Биржийн арилжааны зарчмаар нэгж эрхийн арилжаа нь байнга, тасралтгүй явагдана.

### Төлбөр тооцоо

Сангийн нэгж эрхийг худалдан авсан, худалдсаны төлбөр тооцоо нь арилжаа хийсэнээс хойш ажлын 2 өдөрт хийгдэнэ. Багцийн арилжааны хувьд талууд төлбөр тооцоо хийх өдрийг харилцан тохирч болох бөгөөд энэ өдөр нь арилжаа хийсэнээс хойш ажлын 5 өдрөөс хэтрэхгүй байна.

2026-03-24 Сангийн нэгж эрхийн танилцуулга

БҮРТГЭВ-02

Олон нийтэд мэдээлэл хүргэх

BBSA



Санхүүгийн зохицуулах хорооноос нэгж эрхийг бүртгэх зөвшөөрөл гарснаар Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь Гоулд Траст Биржээр арилжаалагддаг сангийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэнэ. Мэдээллийг өөрийн вебсайт болон олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол хүргүүлж, нэгж эрхийн танилцуулга болон тараах материалыг үнэт цаасны компаниудад хүргүүлнэ.

Хөрөнгө оруулагч нь Кастодиан банкны тооцоолсон сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ, нэгж эрхийн зах зээлийн үнэлгээг брокерийн компаниуд, хөрөнгийн биржийн болон сангийн веб хуудаснаас харах боломжтой.

### Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа

Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь мэргэжлийн түвшинд санд менежментийн үйлчилгээг үзүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн дагуу сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулна. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь өөрийн томилсон сангийн менежерээр дамжуулан Сангийн өмнө хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлнэ.

Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь сангийн нэгж эрхийн танилцуулгыг тогтмол олон нийтэд мэдээлж хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх үйл ажиллагааг хийх бөгөөд сангийн үйл ажиллагааг удирдлагаар ханган ажиллах юм. Үүндээ сангийн хөрөнгийн удирдлага, арилжааны үйл ажиллагааг хэрэгжүүлэн зохистой удирдлагаар хангах, сангийн нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөх, нэгж эрх эзэмшигчдийн хурал зохион байгуулах гэх мэт хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд тусгагдсан удирдлагаар хангах юм.

### БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

Сангийн үйл ажиллагааг жигд, тасралтгүй явуулан сангийн гишүүдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор сангийн хяналтын тогтолцоо ажиллах бөгөөд ийнхүү хяналтын тогтолцоог бүрдүүлснээр сангийн үйл ажиллагаанд үүсч болзошгүй эрсдэлийг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх үр дүнтэй.

Сангийн хяналтын тогтолцооны хяналтыг хэрэгжүүлэх этгээдүүд нь бие биенээ шатлан захирахгүй, нэг нэгэндээ үүрэг даалгавар оноохгүй бөгөөд бие биенээсээ харилцан хамааралгүйгээр хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Сангийн хяналтын тогтолцоо нь сангийн үйл ажиллагааны шат бүрт хэрэгжинэ. Үүнд:

- Дотоод хяналт;
  - Сангийн Төлөөлөн удирдах зөвлөл нь сангийн үйл ажиллагаанд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Кастодиан хяналт;
  - Кастодиан нь гэрээний үндсэн дээр ХОМК нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан журам, заавар, сангийн дүрэм, журмаар тогтоосон, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан болон хөрөнгө

**БҮРТГЭВ-02** оруулалтын сантай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавина.



- Хөндлөнгийн аудит;
  - Санхүүгийн тайлангийн жил дуусах тухай бүр сан нь хөндлөнгийн аудитын байгууллагаар аудитын шалгалт хийлгэж нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын стандартын хэрэгжилтэд хяналт тавих
- Төрийн хяналт.
  - Сангийн үйл ажиллагаанд тавих Санхүүгийн Зохицуулах Хорооны хяналт нь сангийн үйл ажиллагаа нь хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянана.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

“Би Би Эс Эй ҮЦК” ХХК нь 2011 оны 4 дүгээр сарын 22-нд уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч байгууллагад нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн зөвлөгөө үзүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдаж улмаар Монголын хөрөнгийн бирж дээр гадаадын болон дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагч нарын сонирхлыг татахуйц хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн болох биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах зорилгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 63 тоот тогтоолоор Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авсан болно.

### Компаний эрхэм зорилго

Хөрөнгө оруулагч нарт олон улсын хөрөнгө оруулалтын стандарт бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж, дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

### Үйл ажиллагааны чиглэл

“Би Би Эс Эй ҮЦК” ХХК нь хэд хэдэн төрлийн хөрөнгө оруулалтын сангууд үүсгэн байгуулах, түүний хөрөнгийг итгэмжлэн удирдах, төлөөлөх зэрэг үндсэн үйл ажиллагаа явуулах бөгөөд хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг санхүүгийн үр өгөөж бүхий хөрөнгө оруулалтад байршуулж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг эрхэмлэж, менежментийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж ашигт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулна.

### Удирдлагын боловсон хүчин болон бүтэц зохион байгуулалт

Тус компаний эрх бүхий этгээдүүд нь банкны салбарт сүүлийн 20 гаруй жил хөрөнгийн удирдлага, санхүүгийн удирдлага чиглэлээр дагнан ажилласан мэдлэг, туршлага, үр чадвар, харилцаа холбоонд өөрийн үйл ажиллагааг явуулахаар зорьсон. Бид хөрөнгө оруулалт, менежментийн үйл ажиллагаагаа явуулахдаа дотоод, гадаадын брокер, кастодиантай нягт холбоотой ажиллаж хөрөнгө оруулагчдын хөрөнгийг мэргэжлийн түвшинд зөв зохистой удирдаж, мэдээллийг цаг тухай бүрт үнэн зөв хүргэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэн тэргүүнд тавьж ажиллана.

Манай баг, хамт олон нь мэргэжлийн шаардлага хангасан, мэдлэг, үр чадвар бүхий мэргэжилтнүүд бөгөөд нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн үнэлгээ, андеррайтор, брокер дилер зэрэг нарийн мэргэжлийн үйл ажиллагааг дагнан эрхэлдэг байгууллагуудтай хамтарч ажиллаж байна.

### Удирдлагын баг

Компаний удирдлага болон нийт багийн гишүүд нь банк санхүү, менежментийн чиглэлээр мэргэшсэн, бие биенээ орлох чадвартай, ажил мэргэжлийн дадлага туршлагатай байх шаардлагыг бүрэн хангасан болно.

2026.03.24

БҮРТГЭВ-02

Сангийн нэгж эрхийн танилцуулга

BBSA®

Компаний дотоод журмаар үүрэг хариуцлага, ажилтан бүрийн эрх мэдэл, ажил үүрэг, удирдлагын бүтэц тогтолцооны дагуу харилцаа зэргийг тусгаж, ажилтан нэг бүртэй ажил үүргийн хуваарь, харилцагчийн болон компаний дотоод мэдээллийн нууцлалын гэрээ зэрэг бичиг баримтаар харилцан бүрэн дүүрэн ойлголцсон байна.

Компаний өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн зохион байгуулах удирдлагын багийн товч намтар

#### **Гүйцэтгэх захирал Ч. Сайнбилэг**

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн байдал:

- 1993-1997 онд МУИС Банкны эдийн засагч-Мэдээлэл зүйч Бакалавр
- 2006-2008 онд California International University, Los Angeles MS in International Business

Ажлын туршлага:

- 1997-2009 Монгол Шуудан банканд дилер, Нөөцийн удирдлагын хэлтсийн захирал
- 2010-2013 ББС Велт ББСБ ХХК-д Гүйцэтгэх захирал
- 2013-2016 Хадгаламжийн даатгалын корпорацид Дэд захирал
- 2017-2020 Тээвэр хөгжлийн банканд Санхүү эрхэлсэн Гүйцэтгэх захирлын орлогч

#### **Хөрөнгө оруулалтын зөвлөх Ж.Батаа**

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн байдал:

- 1990-1994 онд МУИС Эдийн засагч Бакалавр
- 1999-2000 онд University of Birmingham, England MBA

Ажлын туршлага:

- 1996-2000 Монгол Шуудан банканд дилер, ахлах дилер
- 2001-2008 Худалдаа хөгжлийн банк, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал
- 2008-2010 Кредит Монгол ББСБ, Гүйцэтгэх захирал
- 2010-2017 Монголбанк, Санхүүгийн зах зээлийн Газрын захирал, хэлтсийн захирал
- 2017-2020 Тээвэр хөгжлийн банк, Гүйцэтгэх захирлын орлогч
- 2021-2024 Хөгжлийн банк Тэргүүн дэд захирал, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
- 2025 - БиБиЭсЭй ХХК ТУЗ-н дарга, хөрөнгө оруулалтын менежер

#### **Сангийн менежер С.Батсайхан**

Мэргэжлийн боловсрол эзэмшсэн байдал:

- Хүмүүнлэгийн ухааны их сургууль Англи хэлний бакалавр



Сангийн нэгж эрхийн танилцуулга  
2026-03-24

БҮРТГЭВ

2019 онд МУИС Бизнесийн сургуулийг Банк, Санхүү мэргэжлээр бакалавр

BBSA



- 2020 оноос МУИС Бизнесийн сургуульд Магистрант
- Ажлын туршлага:
- 2019-2021 онд Тээвэр Хөгжлийн Банкны хөрөнгө зохицуулалтын дилерээр ажилласан.
  - 2025 - БиБиЭсЭй ХХК-д хөрөнгө оруулалтын сангийн менежер

## АЛТНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА:

### Алт гэж юу вэ?

Алт бол гялалзсан харагдах байдал, хомсдолтой байдгаараа түүхийн туршид хүн төрөлхтний үнэлж байсан үнэт металл юм. Энэ нь түүхийн туршид үнэт эдлэл, мөнгө болгон өргөн хэрэглэгдэж ирсэн бөгөөд саяхан электроник, анагаах ухаан, тэр ч байтугай тансаг хоолонд хэрэглэгдэх болсон.

Алтны олон улсын мөнгөн тэмдэгтийн нэршлийг "XAU" /ISO:4217 стандартын дагуу 1 трой унц алт/ гэдэг.

Түүхэнд мөнгөн тэмдэгт болгон ашиглаж байсан алт нь цаасан мөнгийг алтаар эргүүлэн авах боломжтой алтны стандартыг бий болгоход ашиглагдаж байсан. Өмнө нь хэд хэдэн улс мөнгөн тэмдэгтээ алттай холбодог байсан. Энэ нь тийм байхаа больсон ч энэ нь төв банкуудын хадгаламжийн тодорхой хэсгийг хөрвөх чадвартай нөөцийн нэг хэлбэр хэвээр байна.

Хэдийгээр түүнийг арилжааны хэрэгсэл болгон ашиглах нь илүү орчин үеийн төлбөрийн аргуудаар солигдсон ч алт нь үнэ цэний найдвартай хадгалалт гэдгээрээ дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэвээр байна. Энэ нь санхүү, хөрөнгө оруулалтын ертөнцөд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эдийн засгийн тодорхойгүй байдлаас хамгаалах хамгаалалт болж, хөрөнгө оруулагчдад их хэмжээний өгөөж өгөх чадвараа харуулдаг.


Алт олборлолтыг өндөр өртөгтэй аргаар гаргаж авдаг. Бусад түүхий эд жишээлбэл газрын тос гэх мэт бусад түүхий эдээс ялгаатай нь алтыг устгах боломжгүй бөгөөд үйлдвэрлэсэн хэмжээ нь зах зээлийн эргэлтэд хэвээр үлдэж, ирээдүйд дахин боловсруулж ашиглах боломжтой байдаг.

Дэлхийн санхүүгийн зах зээл дээр алтны үнийг тодорхойлдог биржүүд дээр арилжаалагддаг буюу төв банкнууд, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулдаг алт нь 99.9 сорьцтой мөнгөжсөн алт байдаг. Мөнгөжүүлсэн алт гэдэг нь олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, биржийн шаардлагын дагуу гулдмайлуулсан, олон улсын санхүүгийн аль нэг төвд хадгалуулж байгаа, борлуулахад бэлэн болсон алт юм.

### Алтны зах зээл гэж юу вэ?

Алтны зах зээл гэдэг нь биет алт болон түүний үүсмэл үнэт цаасыг дэлхийн хэмжээнд буюу бүх цагийн бүсээр, бүх арилжааны сувуудаар арилжаалж буй зах зээл юм.

Үүнд биет алтны арилжаа болон биржийн арилжааны сан (ETFs), фьючерс, опционы зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүд багтана.




Data as of 31 March, 2024

Sources: ICE Benchmark Administration, Metals Focus, Refinitiv GFMS, World Gold Council; Disclaimer

Алтны эрэлтийн ихээхэн хэсгийг төв банкнууд болон хөрөнгө оруулагчид эзэлж буйг дээрх графикаас харж болно. Энэ утгаараа алт нь зөвхөн түүхий эд төдий биш дэлхий хөрөнгийн зах зээлийн чухал хөрөнгө оруулалтын хэрэгсэл юм.

Алтны зах зээлийн өдрийн арилжааны дүнг бусад хөрөнгө оруулалтын хэрэгслүүдтэй харьцуулсан байдлыг доорх графикаас харна уу.



**Зах зээлд оролцогчид:**

- Алт олборлогч болон цэвэршүүлэх компаниуд буюу Ханган нийлүүлэгчид
- Үнэт эдлэлийн дэлгүүрүүд, төв банкнууд, үнэт металлын сангууд, арилжааны банкнууд, хадгаламжийн газрууд, хөрөнгийн биржүүд, хамтын сангууд буюу арилжаачид, зуучлагчид
- Хувь хүн, хуулийн этгээд, хөрөнгө оруулалт, тэтгэврийн сан гэх мэт хөрөнгө оруулагчид

## Gold trading volumes

	FY 2024	YTD NOV 2025	AUG 2025	SEPT 2025	OCT 2025	NOV 2025
<b>OTC</b>						
LBMA	113.49	158.84	155.85	174.48	225.37	188.87
Spot	76.34	116.53	116.96	133.54	174.68	125.62
Swap/forward	26.20	30.32	31.61	30.08	36.75	33.53
Loan/lease/deposit	8.55	8.58	4.87	5.90	7.92	6.12
Option	2.40	3.35	2.42	5.37	6.38	2.51
Non-LBMA (Mid)	6.36	7.34	7.78	8.72	11.27	8.41
Non-LBMA (Low)	3.15	3.97	3.89	4.36	5.63	4.22
Non-LBMA (High)	3.54	11.91	11.57	13.09	16.90	12.67
Shanghai Gold Exchange	7.85	9.95	7.97	9.23	10.63	19.20
ShFE	6.42	7.81	5.83	5.75	7.86	7.77
Other	1.43	2.15	2.14	2.48	2.77	2.42
<b>Total OTC</b>	<b>127.70</b>	<b>175.73</b>	<b>171.40</b>	<b>191.43</b>	<b>247.27</b>	<b>187.51</b>
<b>Exchanges</b>						
COMEX	22.38	113.40	82.97	131.29	195.53	148.99
Futures	57.29	80.03	68.62	97.27	151.04	123.31
Options	15.06	24.37	16.36	34.03	44.54	35.68
Shanghai Futures Exchange	24.03	50.45	35.11	46.11	55.69	50.82
Shanghai Gold Exchange	2.01	3.80	2.29	4.08	6.76	4.73
Deferred	1.38	3.06	1.99	3.41	5.49	4.14
Au9999 and other spot	0.45	0.59	0.35	0.58	1.54	0.48
SHFE	0.18	0.14	0.07	0.05	0.13	0.11
All other exchanges	3.60	5.44	3.45	7.09	11.87	6.51
<b>Total Exchanges</b>	<b>162.23</b>	<b>173.08</b>	<b>113.82</b>	<b>188.57</b>	<b>299.99</b>	<b>220.90</b>
<b>Gold ETFs</b>						
North America	2.28	5.36	1.65	6.50	12.52	8.04
Europe	0.30	0.51	0.29	0.55	1.19	0.73
Asia	0.32	1.12	0.55	1.23	2.09	1.55
Other	0.02	0.03	0.03	0.03	0.07	0.03
<b>Total gold ETFs</b>	<b>2.91</b>	<b>7.02</b>	<b>4.51</b>	<b>8.31</b>	<b>16.88</b>	<b>10.36</b>
<b>Total</b>						
<b>Global gold market liquidity</b>	<b>232.33</b>	<b>354.84</b>	<b>289.75</b>	<b>388.32</b>	<b>561.84</b>	<b>416.77</b>

Data as of 30 November 2025

Sources: Bloomberg, Nasdaq, COMEX, ICE Benchmark Administration, Shanghai Gold Exchange, Shanghai Futures Exchange, ETF providers, Multi Commodity Exchange of India, Dubai Gold & Commodities Exchange, Japan Exchange Group, Thailand Futures Exchange, Bursa Istanbul, Bursa Malaysia, Korea Exchange, World Gold Council. Disclaimer: <https://www.gold.org/terms-and-conditions/proprietary-rights>  
Note: To purchase historical CME data, please visit CME DataMine: <https://data.cme.com>

GOLDHUB.COM



### Алтны арилжааны үнэ хаана тогтодог вэ?

Алтыг арилжааг үндсэндээ биржийн болон биржийн бус (ОТС) гэж ангилдаг. Лондон бол зах зээлийн тоглогчид хоорондоо шууд худалдаа хийдэг буюу ОТС зах зээлийн дэлхийн төв юм. Хэдийгээр энэ зах зээл зохицуулалт багатай, илүү уян хатан зэрэг давуу талтай боловч эрсдэл өндөр байх сөрөг талтай.

Дэлхийн гурван том алтны зах зээл дээр нийт алтны арилжааны 90 гаруй хувь нь арилжаалагддаг. Эдгээр нь:

1. Лондонгийн ОТС зах зээл. Лондонгийн үнэт эдлэлийн зах зээлийн холбоо (LBMA) алтны үнийг өдөрт хоёр удаа тогтоодог бөгөөд энэ нь алтны дэлхийн жишиг болдог.
2. Чикагогийн барааны бирж (CME) групп нь АНУ-ын фьючерсийн зах зээлийг (COMEX дериватив бирж) ажиллуулдаг. Цөөн хэдэн гэрээ нь гүлдмай нийлүүлэх биет байдлаар биелдэг ч алтны үнэ тогтооход улам бүр чухал бирж болж байна.
3. Хятадад Шанхайн алтны бирж (SGE) байдаг бөгөөд 2016 онд Шанхайн алтны үнийн жишгийг эхлүүлсэн дэлхийн хамгийн том биет алтны бирж юм. Мөн Шанхайн фьючерсийн зах зээл (SHFE) хөл хөдөлгөөн ихтэй биржийн нэг юм.

2026-03-24

БҮРТГЭВ-02

Сангийн нэгж эрхийн танилцуулга

BBSA



Сүүлийн үеийн үзүүлэлтүүдээс хархад Дубай, Энэтхэг, Япон, Сингапур, Хонг Конг зэрэг бусад хоёрдогч зах зээлүүд хүч түрэн орж ирж байна.

### Алтны үнэд нөлөөлөгч хүчин зүйлс

Алтны үнэ нь суурь (фундаментал), эдийн засаг, мөн сэтгэлзүйн олон хүчин зүйлийн нарийн нийлбэрээс хамаардаг. Эдгээр хүчин зүйлсийг дараах үндсэн ангиллуудад хуваагч болно. Үүнд:

#### 1. Нийлүүлэлт ба эрэлтийн динамик

Нийлүүлэлт, эрэлтийн үндсэн хууль алтны үнэд суурь нөлөө үзүүлдэг.

##### Эрэлтийн эх үүсвэрүүд:

**Үнэт эдлэлийн үйлдвэрлэл:** Түүхэн хувьд эрэлтийн хамгийн том бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ялангуяа Энэтхэг, Хятад зэрэг орнуудад өндөр байдаг.

**Хөрөнгө оруулалтын эрэлт (аюулгүй орогнол):** Үнэ цэнийг хадгалах зорилгоор алтны гүлдмай, зоос, мөн алтанд суурилсан биржээр арилжаалагддаг сан (ETF) болон хамтын хөрөнгө оруулалтын сангуудыг худалдан авах.

**Төв банкуудын худалдан авалт:** Нөөц хөрөнгө болгон хадгалахын тулд төв банкуудаас албан ёсоор алт худалдан авах нь үнийг мэдэгдэхүйц өсгөх хүчин зүйл болдог.

**Технологи ба үйлдвэрлэлийн хэрэглээ:** Алт нь өвөрмөц физик шинж чанартай тул электроник, шүдний эмчилгээ, анагаах ухаанд ашиглагддаг.

##### Нийлүүлэлтийн эх үүсвэрүүд:

**Уурхайн олборлолт:** Шинээр олборлож буй алтны хэмжээ. Шинэ орд ховор илэрч, олборлолтын процесс удаан хугацаа шаарддаг тул үйлдвэрлэлийн огцом өөрчлөлт ховор тохиолддог.

**Дахин боловсруулсан алт:** Хаягдал үнэт эдлэл, электрон хог хаягдлаас гарган авсан алт бөгөөд үнийн хэлбэлзэлд илүү мэдрэмтгий, тогтворгүй байдаг.

#### 2. Эдийн засаг ба мөнгөний бодлогын хүчин зүйлс

Эдгээр нь богино болон дунд хугацаанд алтны үнийг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйлүүд байдаг.

##### Хүүгийн түвшин ба мөнгөний бодлого:

**Хүүгийн түвшин:** Алт нь хүү өгдөггүй хөрөнгө тул төв банкууд (жишээлбэл, АНУ-ын Холбооны Нөөцийн Систем) хүүгийн түвшинг өсгөх үед бонд, хадгаламж зэрэг өөр хөрөнгүүд илүү сонирхол татах болж, алт барих боломжийн зардал нэмэгддэг. Үүний үр дүнд алтны үнэ буурах хандлагатай байдаг. Харин хүү буурах үед эсрэгээр нөлөөлнө.

**Бодит хүүгийн түвшин:** Нэрлэсэн хүүгээс инфляцыг хассан үзүүлэлт. Бодит хүү бага эсвэл сөрөг үед алтны гүйцэтгэл сайн байх хандлагатай.

##### Инфляц:

2026-03-24

БҮРТГЭВ-02

Сангийн нэгж эрхийн танилцуулга

BBSA®



Алтыг ихэвчлэн инфляцаас хамгаалах хэрэгсэл гэж үздэг. Инфляц өсөж, цаасан мөнгөний худалдан авах чадвар буурах үед хөрөнгө оруулагчид хөрөнгөө хамгаалахын тулд алт худалдан авдаг бөгөөд энэ нь үнийг өсгөдөг.

### **Валютын ханш (АНУ-ын доллар):**

Алт нь дэлхий даяар АНУ-ын доллараар (USD) үнэлэгддэг тул ихэвчлэн урвуу хамаарал ажиглагддаг.

- Доллар чангарвал бусад валюттай хөрөнгө оруулагчдад алт илүү үнэтэй болж, эрэлт буурч, алтны үнэ доошлох хандлагатай.
- Доллар сулрахад гадаад худалдан авагчдад алт хямд болж, эрэлт нэмэгдэн, алтны үнэ өсөх хандлагатай.

### **Эдийн засгийн тодорхойгүй байдал:**

Эдийн засгийн тогтворгүй байдал, зах зээлийн савлагаа, санхүүгийн хямралын үед алт нь “аюулгүй орогнол” хөрөнгө гэж үзэгддэг тул эрэлт огцом нэмэгдэж, үнэ өсдөг.

### **3. Геополитик ба зах зээлийн сэтгэлзүйн хүчин зүйлс**

Эдгээр хүчин зүйлс нь тодорхойгүй байдлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдыг “аюулгүй байдал руу шилжих” зан төлөвт хүргэдэг.

**Геополитикийн тогтворгүй байдал:** Олон улсын мөргөлдөөн, улс төрийн хямрал, дайн, худалдааны маргаан зэрэг нь дэлхийн хэмжээнд айдас, тодорхойгүй байдлыг нэмэгдүүлдэг. Ийм үед хөрөнгө оруулагчид эрсдэлтэй хөрөнгөөс татгалзаж, алт руу хошуурдаг бөгөөд энэ нь үнийг өсгөдөг. Сүүлийн үед гадаадын олон төв банкууд гадаад валютын нөөц дэх алтны хэмжээг эрс ихэсгэж байна.

### **Хөрөнгө оруулагчдын сэтгэл зүй ба спекуляци:**

Эдийн засгийн мэдээ, дэлхийн үйл явдлаар тодорхойлогдох хөрөнгө оруулагчдын нийтлэг хандлага нь үнийг хурдан хөдөлгөж чадна. Мөн фьючерс зах зээл дэх спекуляци, алтны ETF-үүд рүү орох болон гарах их хэмжээний хөрөнгийн урсгал нь алтны үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг.

### **4. АНУ-н төсвийн алдагдал**

Төсвийн алдагдал гэдэг нь тодорхой хугацаанд засгийн газрын зардал орлогоосоо (татвараас) давсан нөхцөл байдлыг хэлнэ. Засгийн газар их хэмжээний алдагдалтай ажиллах үед түүнийг санхүүжүүлэхийн тулд засгийн газрын бонд (жишээ нь, АНУ-ын Төрийн сангийн үнэт цаас) гарган зээл авдаг.

Алтанд үзүүлэх нөлөө:

- Итгэл алдагдах: Удаан хугацаанд үргэлжилсэн, асар их төсвийн алдагдал нь засгийн газрын санхүүгийн сахилга бат, эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдалд итгэх итгэлийг сулруулдаг. Үүний улмаас хөрөнгө оруулагчид фиат мөнгө болон засгийн газрын бондоос гарч, алт зэрэг “аюулгүй” хөрөнгүүд рүү шилждэг.
- Өр ба үнэгүйдлийн суурь: Томоохон алдагдлууд нь шууд улсын өрийг нэмэгдүүлж, мөн төв банк хүүг бага түвшинд барих, эсвэл хамгийн муу хувилбараар мөнгө хэвлэж алдагдлыг нөхөх дарамтад орох магадлалыг нэмэгдүүлдэг. Энэ нь эцэстээ



## 5. Улсын гадаад дотоод өр

Улсын өр ДНБ-тэй харьцуулахад хэт өсөх үед засгийн газар эдийн засгийн өсөлтийг золиослохгүйгээр, татварыг огцом нэмэхгүйгээр эсвэл мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулалгүйгээр өрийн хүүг төлж чадах эсэх талаар эргэлзээ үүсдэг. Өр ихсэх → Алтны үнэ өсөх

## 6. Валютын үнэгүйдэл

Орчин үеийн нөхцөлд валютын үнэгүйдэл гэдэг нь мөнгөний нийлүүлэлт хэт ихэссэнээс үүдэн валютын худалдан авах чадвар буурахыг хэлнэ.

- Үнэ цэнийн хадгалалт: Энэ нь алтны үнэ цэнийн хамгийн шууд үндэслэл юм. Алтыг хэвлэж болдоггүй, үнэгүйдүүлэх боломжгүй. Түүний нийлүүлэлт бодитойгоор хязгаарлагдмал тул эцсийн үнэ цэнийн хадгалалт болдог.
- Инфляц: Валютын үнэгүйдэл нь инфляц үүсгэдэг (хэт их мөнгө, хэт цөөн бараа). Алт нь уламжлалт инфляцын хамгаалалт учраас фиат мөнгөний худалдан авах чадвар унах үед хөрөнгө оруулагчид алт худалдан авч хөрөнгөө хамгаалдаг.
- Фиат бус хөрөнгийн шилжилт: Валютын үнэгүйдлийн айдас нь “үнэгүйдлийн арилжаа” (Debasement Trade) гэж нэрлэгдэх үзэгдлийг өдөөдөг. Энэ үед хөрөнгө оруулагчид уламжлалт фиат мөнгөний системээс гадуурх хөрөнгүүд рүү, тухайлбал алт (мөн сүүлийн жилүүдэд криптовалют) руу хөрөнгөө шилжүүлдэг.

Валютын үнэгүйдлийн эрсдэл өсөх → Алтны үнэ өсөх

## Яагаад алтанд хөрөнгө оруулах нь ашигтай вэ?

1. Алт нь инфляцийн эрсдэлээс хамгаалах, үр хүүхэддээ өв үлдээх хамгийн үр дүнтэй хөрөнгө юм. Учир нь:
  - Алт нь санхүүгийн хямралын үед түүхэндээ сайн ажилласан тул хөрөнгө оруулагчид үүнийг багцын төрөлжүүлэх, хөрвөх чадварын эх үүсвэр болгон ашиглах боломжтой гэсэн үг юм.
  - Алт нь эзэмшигчийн зээлжих чадвараас үл хамаарах үнэ цэнтэй ховор нөөц учраас олон мянган жилийн турш үнэ цэнээ хадгалсаар ирсэн.
  - Алт нь бусад санхүүгийн хөрөнгийн авчрах эрсдэлийг удирдахад хөрөнгө оруулагчдад тусалдаг; илүү тэнцвэртэй, тогтвортой багц бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байна.
2. Алт нь хөрвөх чадвар өндөртэй нэг төрлийн валют. Учир нь:
  - Алтыг нүсэр, хөдөлгөөнгүй хөрөнгө гэж үзэх нь өнөөгийн алтны зах зээлийн бодит байдалтай нийцэхгүй. Алт чөлөөтэй үрсаж, өдөр бүр 163 тэрбум

2026-02-24

Сангийн нэгж эрхийн танилцуулга

БҮРТГЭВ-02

BBSA



ам-доллар арилжаалагддаг нь санхүүгийн гол хэрэгслүүдийн арилжаанаас давсан үзүүлэлт юм.

- Алт нь хөрвөх чадвар өндөртэй учраас өсөлт, уналтын аль ч үед ашигтай байршуулах боломжтой.

3. Алт нь өрсөлдөхүйц өгөөжтэй нь батлагдсан хөрөнгө юм. Учир нь:

- 1971 оноос хойш алтны өгөөж нь хувьцааныхтай ижил, бондын гүйцэтгэлээс давсан байна. Сүүлийн 20 жилийн хугацаанд алт ихэнх хөрөнгийн үндсэн ангиллаас илүү гарсан. Сүүлийн 20 жилд алтны дэлхийн хөрөнгө оруулалтын эрэлт жилд дунджаар 10%-иар өссөн байна.
- Хэрэглээний түүхий эд, хөрөнгө оруулалтын хэрэгсэл гэсэн хоёрдмол шинж чанараараа алт түүхэндээ үнэ цэнээ хадгалсаар ирсэн. Мөн валютаас ялгаатай нь алтыг хэвлэх боломжгүй, зөвхөн олборлодог. Энэ нь яагаад алтны өгөөж бүх гол валютаас байнга илүү байдгийг сайн тайлбарлаж байна.

### Алтанд хэрхэн хөрөнгө оруулах вэ?

Алтан хөрөнгө оруулах аргуудыг шууд болон шууд бус гэж хувааж болно. Биет алт худалдан авах буюу алтан гүлдмай, зоос, алтан үнэт эдлэл худалдаж авах нь шууд аргад орно. Алтны гэрчилгээ худалдан авах, алтны фьючерс болон опшин арилжаа, алтны хамтын санд хөрөнгө оруулах, алтны ханшны зөрүүний гэрээ худалдан авах, Алт олборлодог компаниудын хувьцаа, тэдгээрийг нэгтгэсэн индекс худалдан авах зэрэг нь шууд бус арга юм.


1. Биет алт худалдан авах:

Давуу талууд:

- Сэтгэл зүйн нөлөө. Бодит алтан гүлдмай нь дансны тоон үзүүлэлттэй харьцуулахад илүү найдвартай алтны хөрөнгө оруулалтын хувилбар юм шиг санагддаг.
- Ашиглах боломж. Алтаар хийсэн эд зүйл, хувийн гоёл чимэглэлийг ашиглах нь өдөр тутмын тансаг хэрэглээний нэг хэсэг юм.

Сул талууд:

- Зарим банкууд биет алт худалдан авахыг хүсвэл оршин суугч бус хүмүүст нэмэлт шаардлага тавьдаг.
- Хадгалахад хүндрэлтэй. Алтаа банканд хадгалж болно, гэвч банк дампуурах эрсдэл бий. Алтаа гэртээ хадгалах ч бас хүлгай гэх мэт эрсдэлтэй. Мөн шар металл нь исэлдэлтээс зайлсхийхийн тулд байнгын арчилгаа, тусгай хадгалах нөхцөл шаарддаг.
- Хөрвөх чадвар муу байдаг. Үнэт цаас гэх мэт хэрэгсэлтэй адил гэрээсээ гаралгүйгээр хэдхэн товшилтоор алтаа зарж чадахгүй.
- Хөдөлгөөнт байдал нь хүндрэлтэй. Биет алтыг хилийн чанадад тээвэрлэх нь хуулийн тусгай зохицуулагддаг. Хязгаарлалт ихтэй.
- Алтыг зарахад зардал өндөр. Алтан гүлдмайг худалдаж авсан банкандаа амархан зарж болох боловч бусад худалдан авагчид зарахад сорьц тогтоох гэх мэт шалгалт хийхийг шаардлага үүсдэг. Зарим улс орнууд алт зарахдаа НӨАТ ноогдуулдаг.



АНУ-д "алтны гэрчилгээ" нь 1934 он хүртэл АНУ-ын эрдэнэсийн сангаас гаргасан үнэт цаас бөгөөд банканд хадгалуулсан алтны өмчлөлийг нотлох зориулалттай үнэт цаас юм. Өнөө үед "алтны гэрчилгээ" гэдэг нь зээлдэгч, зээлдүүлэгч хоёрын хооронд байгуулсан гэрээ бөгөөд үүний дагуу зээлдэгч зээлсэн мөнгөө буцааж төлөх үүрэгтэй. Хэмжээ нь алтны ханшаас хамаарна. Сертификат эзэмшигч нь жинхэнэ алт эзэмшдэггүй бөгөөд биетээр авах эрхгүй. Мөн үнэт цаас гаргагчийн дампуурлаас хамгаалагдаагүй байдаг.

Алтны гэрчилгээг банкны хадгаламжтай зүйрлэж болно. Олон хөрөнгө оруулагчид банкны алтны дансандаа мөнгө хийсэн боловч биет алт авдаггүй. Үүний оронд тэд урьдчилж тогтоосон хугацаа дуусахад хүчинтэй үнээр хүүгийн хамт мөнгөө буцааж авах эрхтэй байдаг.

Алтны хадгаламжийн сул талууд:

- Банкны зардал шингэсэн байдаг;
- Банк дампуурах эрсдэлтэй. Хадгаламжийн даатгалын сан баталгаагүй. Зарим улс оронд банк дампуурсан тохиолдолд алтны хадгаламж байхгүй болдог.

3. Алтны ETF болон хамтын сан худалдаж авах:

Хөрөнгө оруулагч нь дэлхийн зах зээлийн алтны биет хөрөнгөд хөрөнгө оруулалт хийдэг ETF болон хамтын сангийн хувьцааг худалдаж авдаг. SPDR Gold Shares ETF, iShares Gold Trust нь ийм алтны сангийн жишээнүүд юм. Эдгээр нь хөрөнгө нь 100 хувь өөрийн алтаар баталгаажсан дэлхийн хамгийн том хөрөнгө оруулалтын сангууд юм. Алтны ETF-ийн өөр хувилбар бол алтны хамтын санд (Франклин алт, үнэт металлын сан гэх мэт) хөрөнгө оруулалт хийх явдал юм. Хөрөнгө оруулагчид хөрөнгийн менежментийн компанитай холбоо барьж, мөнгөө тэр компанид (хамтын сан) даатгах ёстой. Дараа нь хүүгийн орлоготой хадгаламжийн гэрчилгээ авдаг.

Давуу тал:

- Алтны хамтын санд хөрөнгө оруулахын тулд хөрөнгийн зах зээлд шууд орох шаардлагагүй.
- Алтны ETF-ийн хувьцааны хөрвөх чадвар өндөр.

Сул тал:

- Элсэлтийн босго: ETF-ийн алтны хувьцааг худалдаж авахын тулд биржийн төлбөр, брокерийн хураамж, менежментийн хураамж авдаг хөрөнгийн биржид хандах шаардлагатай. Хөрөнгө оруулагч нь "мэргэшсэн хөрөнгө оруулагч" гэсэн шалгуурыг хангасан байх ёстой.
- Хөрвөх чадвар: Ихэнх тохиолдолд хамтын санд хөрөнгө оруулалт хийх нь урьдчилж авах шимтгэл төлөхгүйгээр мөнгөө эрт авах боломжийг олгодоггүй. Мөн гэрчилгээний хугацаа дуусах хүртэл хамтын сан алдагдалтай болсон тохиолдолд хөрөнгө оруулагч ашиг болон хөрөнгөө бүгдийг нь алдаж болно.
- Дампуурлын эрсдэл.

4. Алтны CFD арилжаа

CFD гэдэг нь "зөрүүний гэрээ(contract for difference)" гэсэн үг юм. Энэ нь гэрээ эхэлсэн болон дуусгавар болсон өдрөөс эхлэн үнийн дүнгийн зөрүүг төлөх хоёр талын тохиролцоо юм.



Техникийн хувьд энэ нь дараах байдалтай харагддаг: дэлхийн хаанаас ч ирсэн арилжаачин брокерт данс нээлгэж, өөрийгөө баталгаажуулж, дансаа цэнэглэж, хөрөнгө зарах, худалдан авах арилжаа нээдэг. Брокер нь шимтгэл авдаг. CFD нь ХАУ үнийн дүнтэй холбоотой байдаг. Сертификаттай адил арилжаачин жинхэнэ алт эзэмшдэггүй. CFD нь арилжааны нарийн төвөгтэй хэрэгсэл тул тэдгээрийг ашиглах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахаасаа өмнө зөвлөгөө авах эсвэл зуучлалын үйлчилгээг авах зүйтэй.

Давуу тал:

- Оролт хийх босго бага.
- Хамгийн бага хураамж авдаг.
- Short арилжаа нээх боломж.
- Хөшүүрэг. Хөрөнгийн зах зээлийн брокеруудын хөшүүрэг ихэвчлэн 1:10-аас хэтэрдэггүй.
- "Мэргэшсэн хөрөнгө оруулагч" байх албагүй.

Сул тал:

- Хөшүүргээс шалтгаалан багахан ханшийн хэлбэлзэл нь хөрөнгө оруулагчид ашиг эсвэл алдагдалд оруулах боломжтой.

5. Алтны фьючерс болон options арилжаа:

Алтны фьючерсийн арилжаа болон options арилжаа нь CFD алтны арилжаатай төстэй: арилжаачид нь брокерт данс нээлгэж, брокероор дамжуулан өөрийгөө баталгаажуулж, брокерт нээлттэй арилжаа хийх захиалга илгээдэг. Ялгаа нь үнэт цаас хадгалагч нь алтны үнэт цаасны жинхэнэ эзэмшигч болдог. Алтыг түүхий эдээр нь сонирхож буй тохиолдолд бодит (delivery) фьючерсийн гэрээ гол худалдан авах хэрэгсэл болдог. Харин биетээр нь хэрэглэхгүй хөрөнгө оруулагчдын хувьд бодит бус (non delivery) алтны фьючерс нь тохиромжтой сонголт болно.

Давуу тал:

- Баталгаа: Зохицуулагчид болон хөрөнгийн биржүүд брокеруудад хатуу хяналт тавьдаг. Худалдан авсан үнэт цаасыг хадгаламжийн байгууллагад автоматаар бүртгүүлнэ.

Сул тал:

- Нэвтрэх өндөр босго: Хамгийн бага багц худалдаж авах, шимтгэл төлөхийн тулд дор хаяж 1000 ам.доллар шаардлагатай. АНУ-ын бус иргэдэд АНУ-ын хөрөнгийн зах зээл дээр алт арилжаалахын тулд АНУ-ын брокеруудтай хамтран ажиллах эрх бүхий дэд брокер хэрэгтэй болно.
- Нарийн төвөгтэй байдал: Фьючерс ба options нь үүсмэл санхүүгийн хэрэгсэл юм. Тэдний ашиглалтын нөхцөл нь CFD эсвэл биржийн арилжааны сангаас илүү төвөгтэй байдаг тул арилжаачид техникийн үзүүлэлтүүдийг сайн ойлгох хэрэгтэй. "Мэргэшсэн хөрөнгө оруулагч" биш бол үнэт цаасны сонголт хязгаарлагдмал.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Сангийн нэгж эрхийн танилцуулга

2026-03-24

БҮРТГЭВ-02

BBSA® ≡



**Төв банкны алтны нөөцийн тухай:**

Төв банкнууд гадаад валютын нөөцийн тодорхой хувийг алтанд байршуулдаг. Энэхүү хэмжээ нь сүүлийн 6 жилийн дотор огцом өсч, зах зээлээс алт худалдан авалт нь нэмэгдсэн нь алтны үнэд ихээхэн нөлөө үзүүлж байгаа бөгөөд цаашид ч энэ явц нь геополитикын эрсдэл, ам долларт итгэх итгэл бүүрч байгаа гэх мэт олон шалтгаантай холбоотой үргэлжилж байна.

---



**АЛТНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ**

Алтны үнэ цаашид ч өсөх талаар олон банк, санхүүгийн байгууллагууд таамаглал гаргаж байна.



**Алтны үнийн төсөөлөл (2026–2027, үнц тутамд)**

Байгууллага	2026 он	2027 он	Гол тайлбар
RBC Capital Markets	4,600 (дундаж)	5,100 (дундаж)	Хүү буурах, төсвийн алдагдал, геополитик
Deutsche Bank	4,450 (дундаж) / 4,950 (дээд)	5,150	Төв банкны эрэлт, ETF сэргэх, нийлүүлэлт хязгаарлагдмал
J.P. Morgan	4,000 (Q2 2026 хүртэл)	—	Стагфляци, худалдааны эрсдэл, валютын үнэгүйдэл
Goldman Sachs	4,900 (дээд)	—	Төв банк + ETF урсгал
Bank of America	4,538 (дундаж) / 5,000 (дээд)	—	АНУ-ын санхүүгийн доройтол, долларын сулрал
Wells Fargo	4,700 (дээд)	—	Долларын сулрал, геополитик
World Bank	3,575 (дундаж)	3,375	Өсөлт саарах ч өндөр сүүрь тогтоно

*Тайлбар*

- Ихэнх хөрөнгө оруулалтын банкууд: \$4,500–5,000+
- Хамгийн болгоомжтой төсөөлөл: World Bank

Алтны дундаж үнэ, дээд доод хязгаарыг Блүүмбергийн авсан санал асуулгын дүнгээр, ам долларын төгрөгтэй харьцах ханшын төсөөллийг сүүлийн 10 жилийн ханшийн түүхэн дата дээр үндэслэн тооцоолсон (энэ 10 жилийн хугацаанд төгрөгийн ханш унаж байсан үе гэдгийг анхаарна уу) таамаглалыг доорх графикаар харуулж байна.




2026-03-24

Сангийн нэгж эрхийн танилцуулга

БҮРТГЭВ 02

Алтны үнэд нөлөөлөх гол хүчин зүйлс



Ангилал	Bullish (Үнэ өсгөх)	Bearish (Үнэ бууруулах)
Мөнгөний бодлого	АНУ-н Хүү буурах, бодит хүү сөрөг	АНУ-н Бодит хүү өсөх
Санхүүгийн бодлого	Төсвийн алдагдал, өр тэлэх	Санхүүгийн сахилга бат сайжрах
Төв банк	Алт хуримтлуулах	Алт худалдан авалт удаашрах
ETF / хөрөнгө оруулалт	ETF үрсгал нэмэгдэх	ETF-ээс хөрөнгө гадагшлах
Валют (USD)	Доллар том валютуудын эсрэг сулрах	Доллар том валютуудын эсрэг чангарах
Геополитик	Дайн, хориг, хуваагдал	Зөрчил намжих
Зах зээлийн хандлага	Risk-off	Risk-on (хувьцаа руу шилжилт)

## ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ


### Зах зээлийн эрсдэл

### Алтны үнэ ханшийн эрсдэл

Олон улсын эдийн засаг, геополитикийн нөхцөл байдлаас хамаарч алтны ханш нь хором тутамд хэлбэлздэг. Аливаа хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний үнэ нь уналт сэргэлт ээлжилж байдаг. Олон улсын зах зээлд алтны ханш бууралттай байх нь сангийн нэгж эрхийн үнэлгээг бууруулах эрсдэлтэй.

График 4. Алтны үнэ (унц/ам.доллароор)

## Gold prices



Market Data: Provided by ICE Data Services. More Information  
Data Source: Copyright © 2024 FactSet Research Systems Inc. All rights reserved. Multi Commodity Exchange of India Limited



### Валютын ханшийн эрсдэл

Сангийн нэгж эрх дэх хөрөнгө оруулалт нь ам.доллар төгрөгийн ханшаас хамаарах бөгөөд төгрөгийн эсрэг ам.долларын ханш сулрах үед хөрөнгө оруулагчийн хувьд ханшийн алдагдалтай байж болно.

### Хөрвөх чадварын эрсдэл

Сан нь өөрийн худалдсан нэгж эрхийг харилцагчийн хүсэлтээр зах зээлийн ханшаар худалдан авах үүрэгтэй. Иймд хөрөнгө оруулагч худалдан авсан нэгж эрхийг хүссэн үедээ тухайн үеийн зах зээлийн ханшаар худалдах боломжтой.

Олон улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар, арилжааны идэвхээс хамаарч авах, зарах ханш, ханшийн зөрүү буюу spread нь үргэлж өөрчлөгдөж байдаг бөгөөд зах зээлийн эрсдэл маш өндөр эсхүл зах зээлийн хөрвөх чадвар маш бага үед авах, зарах ханшийн зөрүү нэмэгддэг.

### Арилжааны цаг

Олон улсын зах зээл дэх алтны ханшийн хөдөлгөөн нь ажлын өдрүүдэд 24 цагаар өөрчлөгдөж байх боловч Монголын хөрөнгийн биржийн арилжаа нь 10 цагаас 13 цаг хүртэл арилжааны цагаар ажилладаг. Иймд Монголын Хөрөнгийн Биржийн арилжаа хаагдсан үе буюу Европ болон АНУ-н арилжааны цагаар ханшийн хэлбэлзэл өндөр байх магадлалтай. Доорх зургаас хархад эхний өдрийн арилжааны цагаар алтны ханш харьцангуй бага хэлбэлзэлтэй байсан бөгөөд Европын болон АНУ-н биржийн арилжааны цагаар ханшийн хэлбэлзэл өндөр байсан бөгөөд дараагийн өдрийн Монголын хөрөнгийн биржийн арилжааны цаг эхлэхэд хаалтын ханшаас өндөр нээлтийн ханшаар арилжаалагдаж эхэлсэн байна.

### Төлбөр тооцооны эрсдэл

2026-03-24

Сангийн нэгж эрхийн танилцуулга

BBSA

БҮРТГЭВ

Сан нь нэгж эрхээ буцаан худалдан авах үүрэг хүлээсэн бөгөөд энэ тохиолдолд гадаад байх алтаа зарж хөрөнгө оруулагчид төлбөрийг төлнө. Гадаад төлбөр тооцоо саатах, гадаадын банк санхүүгийн байгууллагуудын хяналт хийх хугацаа төлбөр тооцоо хийх өдрөөс хэтрэн удаашрах эрсдэл байна.

#### Үйл ажиллагааны эрсдэл

#### Сангийн удирдлагын үйл ажиллагааны эрсдэл

Сангийн удирдлага нь нэгж эрхийг худалдан авсан хөрөнгө оруулагчийн төлбөр болох эх үүсвэрийг тогтвортой байршуулах, харилцагчийн худалдан авсан нэгж эрхийг олон улсын зах зээлд худалдан авах үүрэгтэй бөгөөд буруу шийдвэр эсхүл алдаа гаргах эрсдэл үүсч болзошгүй. Энэхүү эрсдэлээс сэргийлэхийн тулд сан нь мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдаж байгаа бөгөөд ихээхэн том дүнтэй хэлцэл, арилжааны шийдвэр, хязгаарлалт бүхий хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулах нэгж эрх эзэмшигчдийн хурал, ТУЗ-н зөвшөөрөлтэйгөөр гаргана.

#### Мэдээллийн технологийн эрсдэл

Сан нь нэгж эрхийг худалдах, худалдан авах арилжааг цахимаар хийх бөгөөд олон улсын зах зээлд алтны арилжааг цахимаар хийх тул технологи болон тоног төхөөрөмжийн эрсдэл үүсч болзошгүй. Эрсдэлийг хязгаарлахын тулд сан нь ашиглагдаж буй арилжааны платформыг тогтмол шинэчилж тогтвортой үйл ажиллагаа явуулах шаардлага хангахуйц мэдээллийн систем болон компьютерийн технологи ашиглан ажиллана.

#### Хамтрагчдын дампуурал

Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь өөрийн харилцагч банк, Кастодиан банк, үндсэн оролцогч, брокер гэх мэт хамтран ажиллагч байгууллагуудын үйл ажиллагаа, тогтвортой байдалд хяналт тавин ажиллана. Харилцагч байгууллагуудад санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэл үүсч тэрхүү эрсдэл нь сангийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж болзошгүй болсон тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

#### Хууль эрх зүйн орчноос хамаарсан эрсдэл

Сан нь эрх зүйн зохицуулалттай зах зээлд буюу Санхүүгийн зохицуулах хорооны хяналтанд Монголын хөрөнгийн биржид арилжаалагдах тул хууль эрх зүйн нөхцөлөөс хамаарах хамааралтай. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмуудад гарч болох гэнэтийн өөрчлөлтүүд нь сангийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж болзошгүй. Сан нь олон улсын жишгийн дагуу, хууль журмын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа.



Сангийн нэгж эрхийн танилцуулга

BBSA



## TATVAR

ЭНЭХҮҮ ХЭСЭГ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАТВАРЫН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ЗОРИЛГОТой БИШ БӨГӨӨД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ЭСХҮЛ ИРГЭНШИЛТЭЙ ОРНЫ ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТУСГАЙ НӨХЦӨЛ, ЖУРМААР ЗОХИЦУУЛАГДАХ БОЛОМЖТОЙ. ИЙМД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТА ӨӨРИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ЭСХҮЛ ИРГЭНШИЛТЭЙ ОРНЫ ТАТВАРЫН ОРЧИНТОЙ САЙТАР ТАНИЛЦАН ТАТВАРЫН ЗӨВЛӨХТЭЙ ЗӨВЛӨЛДӨЖ ИЛҮҮ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

### Сангийн орлогод ногдох албан татвар

Сан нь Монгол Улсын “Татварын ерөнхий хууль”, “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай” хууль болон татварын бусад хууль тогтоомжийн зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж, татварын харилцаанд орно.

Сан нь үйл ажиллагаа эрхлэх бүхий л тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өөрчлөлтөөс гадна, үйл ажиллагаанд үүсэх зардлуудтай бөгөөд тайлант хугацаанд үргэлж цэвэр зардалтай ажиллана. Сан нь ногдол ашиг болон хүүгийн орлого зэрэг хөрөнгө оруулалтын орлого олохгүй.

Иймд хөрөнгө оруулагч нь алтны үнийн өсөлтөөс олох орлогод ногдох албан татвар давхар тооцогдохгүй буюу сан нь татвар ногдох орлоготой ажиллахгүй.

### Хөрөнгө оруулагчийн орлогод ногдох татвар

Хөрөнгө оруулагч нь “Татварын ерөнхий хууль”, “Хувь хүний орлогын албан татварын тухай” хууль болон татварын бусад хууль тогтоомжийн зохицуулалтын хүрээнд орлогын албан татвар төлнө. Хөрөнгө оруулагч нь өөрийн хөрөнгө оруулалтын орлогод ногдох албан татварыг хариуцан төлөх юм.

Санг үүсгэн байгуулах үеийн санд хөрөнгө оруулсантай холбогдох татвар нь хувьцааны хөрөнгө оруулалтын татварын орчинтой ижил байгаа бөгөөд сан нь хөрөнгө оруулагчийн нэгж эрхийн арилжааны орлогод ногдох татвар төлөлттэй холбогдох аливаа хариуцлага хүлээхгүй болно.

## ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

### Үндсэн оролцогч, Брокер

Компанийн нэр:	“Би Ди Сек ҮЦК” ХК
Улсын бүртгэлийн дугаар:	9010001030
Регистрийн дугаар:	2052482
Үйл ажиллагааны чиглэл:	Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер

Сангийн нэгж эрхийн танилцуулга  
2026-03-24


Хаяг: БҮРТГЭВ-02

Утас:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Залуучуудын өргөн чөлөө, 27/1, "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн төв байр.

976-11-313108, 976-11-323411

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.bdsec.mn](http://www.bdsec.mn) холбоосоор авна уу.



#### Кастодиан банк

Компанийн нэр:

"Хаанбанк" ХК

Улсын бүртгэлийн дугаар:

Регистрийн дугаар:

2693321

Үйл ажиллагааны чиглэл:

Арилжааны банк, кастодиан банк

Хаяг:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион Оргил 1,  
Чингисийн өргөн чөлөө 6, Хаанбанк цамхаг.

Утас:

976-75153333 (3420)

Custodian банкаар монголын хамгийн том банк болох  
Хаан банк ажиллана. Дэлгэрэнгүй мэдээллийг  
[www.khanbank.com](http://www.khanbank.com) холбоосоор авна уу.

#### Хууль эрхзүйн компани

Компанийн нэр:

"Өмгөөллийн зөвлөх партнер" ХХК

Улсын бүртгэлийн дугаар:

Регистрийн дугаар:

Үйл ажиллагааны чиглэл:

Хуулийн зөвөлгөө, өмгөөлөл

Хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4 хороо, Твин Товер,  
7 давхар

Утас:

99115492, 88137375

И-мэйл хаягаар холбогдоно уу  
[buyna.samdan@yahoo.com](mailto:buyna.samdan@yahoo.com)

#### Аудит

Компанийн нэр:

"Онч Аудит" ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Сангийн нэгж эрхийн танилцуулга  
2026-03-24

БҮРТГЭВ

Улсын бүртгэлийн дугаар:

Регистрийн дугаар:

Үйл ажиллагааны чиглэл:

Хаяг:

Утас:

Нягтлан бодох бүртгэл, бизнесын зөвөлгөө, санхүүгийн аудит

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, ИСС тауэр, 15 давхар

976-99080450


Санхүүгийн аудитын үйлчилгээг зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрөл бүхий, 21 жилийн туршлагатай “Онч Аудит” ХХК үзүүлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.onch.mn](http://www.onch.mn) холбоосоор авна уу.

BBSA®



## ХАВСРАЛТ

ГОУЛД ТРАСТ БАС-Н ДҮРЭМ



2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн тоот “Гоулд траст” өлөр хамтын биржээр арилжаалагддаг сангийн үүсгэн байгуулагчдын хурлын 4 дүгээр шийдвэрээр батлав. 01

**“Би Би Эс Эй ҮЦК” ХХК-ны үүсгэн байгуулсан  
“Гоулд траст” хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн  
дүрэм**



Би Би Эс Эй ҮЦК ХХК  
Гүйцэтгэх захирал  
Гүйцэтгэх Захирал  
Сайнбилэг

**Нэгдүгээр зүйл.  
Ерөнхий зүйл**

1.1 “Гоулд траст” хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан (цаашид “Сан” гэх)-ийн эрх зүйн байдал, зорилго, үйл ажиллагааны чиглэл, хугацаа, удирдлагын бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн эрх үүрэг, хүлээх хариуцлага болон санг татан буулгах нөхцөл журмыг тодорхойлох үндсэн баримт бичиг мөн.

1.2 Сан нь Монгол Улсын Компаний тухай хууль, ҮЦЗЗ-ийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ны холбогдох журам, заавар, тогтоол, шийдвэр болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэн явуулна.

1.3 Сангийн оноосон нэр нь:

- Монгол хэлээр “Гоулд траст” хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан;

- Товчилсон тэмдэглэгээ “Гоулд траст” ХБА ХОС;
- Англи хэлээр “Gold trust” Exchange Traded Fund;
- Товчилсон тэмдэглэгээ “Gold trust” ETF;

1.4 Сангийн албан ёсны хаяг нь:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Би Ди Сек ХК-ны байр, 303 тоот

**Хоёрдугаар зүйл.  
Нэр томъёоны тодорхойлолт**

2.1. Энэхүү дүрэмд тухайлан өөр утгаар хэрэглээгүй тохиолдолд дор дурдсан нэр томъёог дараах утгаар тайлбарлаж хэрэглэнэ. Үүнд:

2.1.1 “Сан” гэж “Гоулд траст” хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан оноосон нэр бүхий санг;

2.1.2 “ХОМК” гэж “Би Би Эс Эй ҮЦК” ХХК оноосон нэр бүхий хөрөнгө оруулалтын менежментийн компани буюу цаашид Спонсор гэх;

2.1.3 “СЗХ” гэж сан болон ХОМК-ийн үйл ажиллагааг зохицуулалтаар хангах, хяналт тавих төрийн эрх бүхий байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороог;

2026-03-24

БҮРТГЭВ



- 2.1.4 “МХБ” гэж хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэх, арилжааг эрхлэн явуулах эрх бүхий байгууллага болох Монголын хөрөнгийн бирж ТӨХК-г;
- 2.1.5 “Нэгж эрх эзэмшигч” гэж Сангийн нэгж эрхийг хоёрдогч зах зээл дээрээс өөрийн хууль ёсны өмчлөлд шилжүүлэн авч нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлд бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийг;
- 2.1.6 “Нэгж эрх” гэж Хөрөнгө оруулагчаас Санд хөрөнгө оруулсныг гэрчлэх нэрийн үнэт цаасыг;
- 2.1.7 “Нэгж эрхийн танилцуулга” гэж хөрөнгө оруулах магадлалтай этгээдэд зориулан Сангийн нэгж эрхийн талаар ХОМК-иас боловсруулсан баримт бичгийн бүрдлийг;
- 2.1.8 “Хөрөнгө оруулалтын сангийн гишүүн” гэж сангийн нэгж эрх эзэмшигч болсон этгээдийг;
- 2.1.9 “Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал” гэж Сангийн нэгж эрх эзэмшигчид нийлж хуралдан шаардлагатай шийдвэр гаргах эрх бүхий Сангийн эрх барих дээд байгууллагыг;
- 2.1.10 “холбогдох хууль тогтоомж” гэдэгт Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх журмуудыг;
- 2.1.11 “өдөр”, “сар” болон “жил” гэдэгт хуанлийн тооллоор тооцсон өдөр, сар, жилийг;
- 2.1.12 “Их хэмжээний хэлцэл” гэдэгт Компаний тухай хуулийн 87.1 дүгээр зүйлд заасныг гэхдээ сангийн өдөр тутмын, хөрөнгө оруулалтын бодлогын дагуу хийгдэж байгаа хэлцлүүд нь их хэмжээний хэлцэлд хамаарахгүй;
- 2.1.13 “Сонирхолын зөрчил” гэдэгт Компаний тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасныг;
- 2.1.14 “Блүүмбэрг мэдээллийн сүлжээ” гэдэг нь олон улсын арилжаа, үнэ ханшийн мэдээллийн систем;
- 2.1.15 “Системийн нөлөө бүхий банк” гэдэг нь Монголбанкнаас тогтоосон системийн нөлөө бүхий арилжааны банкуудыг;
- 2.1.16 “Мөнгөжсөн алт” гэж олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, олон улсын санхүүгийн аль нэг төвд хадгалуулж байгаа, гадаад валютаар борлуулахад бэлэн болсон алтыг;
- 2.1.17 “Мэргэжлийн оролцогч” гэж анхдагч зах зээлд сангийн нэгж эрхийг солилцох гэрээг сантай байгуулсан үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий үнэт цаасны компанийг хэлнэ.
- 2.1.18. “Сагс” гэж спонсороос гаргаж Мэргэжлийн оролцогчид шилжүүлэх тодорхой тооны сангийн нэгж эрхийг;
- 2.1.19. “Сагс дахь сангийн нэгж эрхийн ханш (basket price)” гэж спонсороос тогтоосон сангийн нэгж эрхийн ханш;
- 2.2 Энэхүү дүрэмд тухайлан тайлбарлаагүй нэр томъёог хуульд заасан утгаар нь нэг мөр ойлгож хэрэглэнэ.

**Гуравдугаар зүйл**  
**Сангийн төрөл ба хэлбэр**

2026-03-24

БҮРТГӨӨ

СЗХ

ок сар өдөр

2026-03-24

3.1 Сан нь нэгж эрхээ Мэргэжлийн оролцогчоор дамжуулан худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргах бөгөөд нэгж эрхээ бусдаас байнга эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг, арилжаа эрхлэх байгууллага дээр арилжаалагддаг хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан байна.

#### **Дөрөвдүгээр зүйл.**

##### **Сангийн үндсэн зорилго,**

##### **үйл ажиллагааны чиглэл ба ажиллах хугацаа**

- 4.1 Сангийн үндсэн зорилго нь сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд нэгж эрхийн үнийн хөдөлгөөнөөс үүсэх өгөөж болон эрсдлийг нэгж эрх эзэмшигчдэд хүртээхийг зорино.
- 4.2 Сан нь идвэхгүй удирдлагатай буюу зөвхөн сангийн нэгж эрхийн арилжааны ханшыг тодорхойлох, эрэлт нийлүүлэлтийг хангах, хөрвөх чадварыг хангах зорилготой.
- 4.3 Сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь 10 жил байх ба түүнд сангийн гишүүдийн хурлын шийдвэрээр өөрчлөлт оруулж болно.
- 4.4 Сан нь энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэн явуулахгүй.
- 4.5 Сан нь энэхүү дүрэм, хөрөнгө итгэмжлэн удирдах журам, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг болон бусад журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.


#### **Тавдугаар зүйл.**

##### **Сангийн нэгж эрх ба хөрөнгө**

- 5.1. Сан ширхэг нь 0.01 грамм алттай тэнцэх нийт 500 кг алт буюу 50,000,000 ширхэг нэгж эрх гаргана. Сангийн нэгж эрхийн үнэ нь 0.01 грамм мөнгөжсөн алтны төгрөгөөр илэрхийлсэн дүнг дагаж хөдөлнө. Нийт зарласан 50 сая нэгж эрхийг сагслан анхдагч зах зээлд гаргах бөгөөд нэг сагс нь 50 сая төгрөг орчимын үнэлгээтэй нэгж эрхүүд байна.
- 5.2. Мөнгөжсөн алтыг төгрөгөөр илэрхийлэхдээ тухайн үеийн Блүүмбэрг мэдээллийн сүлжээн дээрхи мөнгөжсөн алтны авах зарах ханшийг системийн нөлөө бүхий банкуудын нийтэд зарласан ам.долларын арилжааны авах зарах ханшийг ашиглан тогтооно.
- 5.3. Сангийн нэгж эрхийг Мэргэжлийн оролцогч сантай байгуулсан гэрээний үндсэн дээр эрх бүхий арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан арилжина.
- 5.4. Сагс дахь сангийн нэгж эрхийн ханшийг сан өөрөө тогтооно.
- 5.5. Сангийн нэгж эрхийг Төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлж хадгалуулна.
- 5.6. Сангийн нэгж эрхийн арилжааны төлбөр тооцоо нь кастодианы хяналт доор хийгдэнэ.
- 5.7. Сангийн нэгж эрх эзэмшигч нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 25.2.1-д заасан эрх эдэлнэ.
- 5.8. Сангийн актив хөрөнгө нь зөвхөн Хөрөнгө оруулалтын бодлогод заасан санхүүгийн хэрэгсэлээс бүрдэнэ.
- 5.9. Хөрөнгө оруулалтын сангийн гишүүн сангийн бусдын өмнө хүлээсэн үүргийг зөвхөн санд оруулсан хөрөнгөөр хариуцна.
- 5.10. Сан нь сангийн гишүүдийн болон санд үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийн бусдын өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг хүлээхгүй.
- 5.11. Сан нь хөрөнгө оруулагч сангийн гишүүдэд сангийн ногдол ашиг хувиарлахгүй.

2026-03-24

БҮРТГЭВ



5.12. Сангийн нэгж эрх нь тухайн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох боловч хөрөнгө оруулалтын сангийн тодорхой хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

5.13 Сангийн нэгж эрх тус бүр адил тэгш хэмжээний хөрөнгийг гэрчилнэ.

5.14 Сангийн нэгж эрхэд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргахыг хориглоно.

### **Зургаа. Сангийн зардал**

- 6.1. Сангийн зардал нь дараахь зардлаас бүрдэнэ. Үүнд:
  - 6.1.1. Санг үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэх зардал;
  - 6.1.2. Сангийн маркетинг сурталчилгааны зардал;
  - 6.1.3. Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний зардал;
  - 6.1.4. Кастодианы үйлчилгээний зардал;
  - 6.1.5. Арилжаа эрхлэх байгууллагын буюу хөрөнгийн биржийн бүртгүүлэх хүсэлт хянах хөлс, бүртгэх үйлчилгээний хөлс, жилийн үйлчилгээний хөлс;
  - 6.1.6. Дотоодын брокерийн үйлчилгээний зардал;
  - 6.1.7. Гадаадын брокерийн үйлчилгээний зардал;
  - 6.1.8. Бусдаас авах зээлийн шугам болон зээлийн хүүгийн зардал;
  - 6.1.9. Аудитын үйлчилгээний зардал;
  - 6.1.10. Хурлын зардал.
- 6.2. Энэхүү дүрмийн 6.1.3, 6.1.4-т заасан зардлуудын нийлбэр дүн нь Сангийн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн 3%-иас хэтрэхгүй байна.
- 6.3. Сангийн нийт зардлын дээд хэмжээ нь сангийн нийт хөрөнгийн дундаж үлдэгдэлийн 10%-иас хэтрүүлэхгүй байна. Энэхүү дүрмийн 6.1.1.-д заасан нэг удаагийн үүсгэн байгуулах зардлыг оруулж тооцохгүй.

### **Долдугаар зүйл.**

#### **Нэгж эрхийг арилжих журам**

- 7.1 ХОМК нь Санг үүсгэн байгуулах баримт бичгийг СЗХ-д бүртгүүлсэнээс хойш нэг сарын дотор сангийн нэгж эрхийн танилцуулгыг боловсруулж, бүртгүүлэх хүсэлтийг СЗХ-д гаргасан байх ба нэгж эрхийн танилцуулага нь холбогдох хууль тогтоомж болон журамд заасан мэдээллийг бүрэн багтаасан байна.
- 7.2 Нэгж эрхийн танилцуулгыг сонирхогч этгээдэд үнэ төлбөргүй танилцуулна.
- 7.3 Нэгж эрхийн танилцуулгыг үндэслэн ХОМК нь нийтээс хөрөнгө төвлөрүүлэх ажиллагааг эрхлэн хэрэгжүүлэхээс гадна үнэт цаасны арилжаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд бүртгүүлэх замаар зохион байгуулна.
- 7.4 Сан нь нэгж эрхийн танилцуулгыг СЗХ болон арилжаа эрхлэгч байгууллагад бүртгүүлсэнээс хойш 6 сарын дотор нийтэд танилцуулж энэ дүрмийн 5-р зүйлд заасан нэгж эрх буюу үнэт цаасаа арилжаалж эхэлсэн байна.
- 7.5 Нэгж эрх худалдан авах сонирхол илэрхийлсэн этгээд нь нэгж эрх худалдан авах гэрээг брокерийн эрхтэй компанитай байгуулна. Нэгж эрхийн захиалга өгөх, нэгж эрх худалдан авах гэрээ байгуулах, нэгж эрхийн төлбөрийг төлөх, нэгж эрхийг бүртгэх талаарх зохицуулалтыг нийтлэг журмын дагуу гүйцэтгэнэ.

### **Наймдугаар зүйл.**

#### **Нэгж эрх эзэмшигчийн бүртгэл ба эрх, үүрэг**

2026-03-24

БҮРТГЭЛ



8.1 Нэгж эрх эзэмшигчдийн тухайлсан бүртгэлийг гэрээт кастодиан болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага давхар хөтлөнө.

8.2 Сангийн менежер нь тухайлсан бүртгэлд үндэслэн бүртгэл хөтлөх бөгөөд Компаний тухай хуулийн 45.3-т заасан мэдээлэл, нэгж эрхийн бүртгэлд бүртгүүлсэн огноог тусгана.

8.3 Сангийн нэгж эрх эзэмшигч гишүүн нь дараах эрхтэй. Үүнд:

8.3.1 Сангийн нэгж эрх нь сангийн хөрөнгөнөөс өмчлөх хувь хэмжээг гэрчилнэ.

8.3.2 ХОМК-иас сангийн хөрөнгийг дүрэм болон хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд мэргэжлийн түвшинд зохих ёсоор удирдахыг шаардах, үйл ажиллагааг зогсоох болон өөрчлөх тухай асуудлыг сангийн гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх санал гаргах;

8.3.3 Сангийн гишүүдийн хуралд өөрийн эзэмшиж буй нэгж эрхэд ногдох саналын эрхтэйгээр оролцох;

8.3.4 Санг татан буулгах үед өөрт ногдох хөрөнгийг хүлээн авах;

8.3.5 Хууль тогтоомжид заасан бусад.

8.4 Сангийн нэгж эрх эзэмшигч нь дараах үүрэгтэй. Үүнд:

8.4.1 ХОМК-ийн хууль тогтоомжийн дагуу Санг удирдах үйл ажиллагаа, шийдвэрт зүй бусаар нөлөөлөх буюу өөрийн үйл ажиллагаанаас хараат байхыг шаардахгүй байх.

8.4.2 Сангийн нэгж эрх эзэмшигч буюу сангийн гишүүн нь эзэмшиж буй нэгж эрхэд ногдох хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

### Ес. Хөрөнгө оруулалтын сангийн мэдээлэл

9.1 Сангийн мэдээлэл нь дараахь төрөлтэй байна. Үүнд:

9.1.1 СЗХ-д хүргүүлэх мэдээлэл;

9.1.2 Хууль тогтоомжид заасан эрх бүхий бусад төрийн байгууллагад гаргаж өгөх мэдээлэл;

9.1.3 Нэгж эрх эзэмшигчдэд хүргүүлэх мэдээлэл.

9.2 СЗХ-д хүргэх мэдээлэлийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, СЗХ-оос баталсан журмын дагуу, бусад эрх бүхий байгууллагад гаргаж өгөх мэдээллийг тухайн байгууллагын шаардлагыг үндэслэн ХОМК-ийн тухайн сангийн менежер гаргаж өгөх үүрэгтэй.

9.3 Сангийн менежер нь дараахь мэдээллийг нэгж эрх эзэмшигчдэд энэ дүрэмд заасан журмаар хүргүүлэх үүрэгтэй. Үүнд:

9.3.1 Сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийн мэдээлэл, гаргасан нийт нэгж эрхийн тоо, шинээр гаргасан болон буцаан худалдаж авсан нэгж эрхийн тоо ширхэг, хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлж буй хөрөнгийн нэр төрөл, тоо ширхэг зэрэг мэдээллийг **өдөр бүр** биржийн арижаа дууссанаас хойш 1 цагийн дотор өөрийн цахим хуудас болон Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх;

9.3.2. Сангийн цэвэр хөрөнгийн өөрчлөлт, хэрэгжсэн болон хэрэгжээгүй ашиг, алдагдлын тооцоолол, удирдлагын зардал, сангийн хөрөнгө, эзлэх хувь зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан сангийн үйл ажиллагааны тайланг Хөрөнгө Оруулалтын Гүйцэтгэлийг Үнэлэх Олон Улсын Стандарт (GIPS)-ын дагуу улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж, улирлын тайланг дараа сарын 10-ны дотор, хагас жилийн тайланг санхүүгийн тайлангийн хамт 7 дугаар сарын 20-ны дотор, жилийн тайланг санхүүгийн тайлангийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 31-ний дотор Биржид хүрүүлж, олон нийтэд мэдээлэх;

2026-03-24

БҮРТГЭВ-02



- 9.3.3. Сангийн гишүүдийн ээлжит болон ээлжит бус хурлын зар, хэлэлцэх асуудалд холбогдох баримт бичиг, мэдээллийг сангийн гишүүдийн хурлаас 14 буюу түүнээс дээш хоногийн өмнө нэгж эрх эзэмшигчдэд хүргүүлнэ. Ээлжит хурлын зард дараах мэдээллүүдийг хавсаргасан байна. Үүнд:
- 9.3.3.1. Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайлан, түүнд өгсөн ТУЗ болон ХОМК-ний дүгнэлт;
  - 9.3.3.2. Сангийн санхүүгийн жилийн тайланд аудитын байгууллагын өгсөн дүгнэлт;
  - 9.3.3.3. Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;
  - 9.3.3.4. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан;
  - 9.3.3.5. Хэлэлцэх бусад асуудалд хамаарах шаардлагатай мэдээлэл;
  - 9.3.3.6. Сангийн гишүүний шаардсан болон сангийн менежер шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.
  - 9.3.3.7. Ээлжит бус хурлаар зөвхөн тухайн хэлэлцэх асуудалд хамаарах мэдээллийг хүргүүлнэ.
- 9.4. Энэ дүрмийн 9.3-т заасан мэдээллийг тухайн мэдээллийн онцлогоос шалтгаалан сангийн гишүүний бүртгэлийг үндэслэн цахим хаягаар, шуудангаар хүргүүлэх эсхүл ХОМК-ийн байранд тухайн мэдээллийг тавьж, сангийн гишүүдийг танилцах бололцоогоор хангах.
- 9.5. Сангийн нууцад хамаарах мэдээллийг цахимаар болон шуудангаар хүргүүлэхийг хориглоно. Нэгж эрх эзэмшигч нь нууц мэдээлэлтэй хөрөнгө оруулалтын менежментийн компанийн байранд танилцах бөгөөд хувилахыг хориглоно. Сангийн үйл ажиллагаатай холбоотой, түүнд үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд, иргэнээс мэдээлэл авахтай холбоотой журмыг СЗХ тогтоох бөгөөд уг мэдээллийг гагцхүү албан хэрэгцээнд ашиглана.
- 9.6. Энэхүү журамд заасан мэдээ, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв хүргүүлэх үүргийг сангийн менежер хариуцна.

#### **Аравдугаар зүйл.**

#### **Хөрөнгө оруулалтын сангийн удирдлага**

- 10.1 Сангийн эрх барих дээд байгууллага нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал буюу Сангийн гишүүдийн хурал байна.
- 10.2 Сан нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба ТУЗ нь гурван хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 10.3 Хөрөнгө оруулалтын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны дагуу хэрэгжүүлнэ.

#### **Арваннэгдүгээр зүйл.**

#### **Сангийн гишүүдийн хурал**

- 11.1 Сангийн гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.
- 11.2 Сангийн нэг ширхэг нэгж эрх нь нэг саналын эрхтэй байна. Хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй гарна. Хурлын тогтоолд хурал даргалагч гарын үсэг зурна.

2026-03-24

БҮРТГЭВ

СЭХ

он сар өдөр

БҮРТГЭВ

№ 01

11.3 Ээлжит хурлыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу 4 дүгээр сарын 30-ны дотор Сангийн ТУЗ зарлан хуралдуулна.

11.4 Сангийн гишүүдийн хурлыг энэ дүрмийн 10.3-т заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болно.

11.5 Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг ХОМК-ний санал, шаардлагаар ТУЗ зарлан хуралдуулна. ТУЗ нь ээлжит бус хурлыг хуралдуулах тухай ХОМК-ийн санал, шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

11.6 ХОМК нь дараах тохиолдолд сангийн гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулах саналыг ТУЗ-д гаргах үүрэгтэй. Үүнд:

11.6.1 Хөрөнгө оруулалтын менежментийн компани татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас шинээр хөрөнгө оруулалтын менежментийн компанид хөрөнгө итгэмжлэн удирдах эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн;

11.6.2 Кастодиан татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас шинээр хөрөнгө хадгалах гэрээний эрхийг өөр кастодианд шилжүүлэх шаардлага үүссэн;

11.6.3 Хөрөнгө оруулалтын менежментийн компанийг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний эрхийг шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах;

11.6.4 Кастодианыг сонгох, хөрөнгө хадгалах гэрээний эрхийг шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах;

11.6.5 Сангийн дотоод хяналтын албанаас нэгжийн эрх эзэмшигчдийн хурлыг хийхийг шаардсан.

11.7 Сангийн гишүүдийн хурлыг ТУЗ дарга буюу түүний томилсон этгээд удирдан явуулна.

11.8 Нэгж эрх эзэмшигч нь өөрийг нь төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа сангийн менежер хурал эхлэхээс өмнө бичгээр мэдэгдэнэ. Сангийн менежер нь хурлын тооллогын комиссын үүргийг гүйцэтгэнэ.

11.9 Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хуралд хүчинтэй. Хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.

11.10 Хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хуралд оролцсон гэж үзнэ.

11.11 Хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл бүртгэнэ.

11.12 Хуралд бэлдэх, хурлын зар мэдээг хүргэх, хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэрийг баталгаажуулах зэрэг энэхүү дүрмээр нарийвчлан зохицуулаагүй бусад асуудлыг холбогдох хууль журмаар зохицуулна.

11.13 Сангийн гишүүдийн хурал хуралдуулахтай холбогдож гарах зардлыг сан хариуцна.

11.14 Сангийн гишүүдийн хурлын ирцийг Компаний тухай хуулийн 69.1 дүгээр зүйлд заасны дагуу тооцно.

**Арванхоёрдугаар зүйл.**  
**Сангийн гишүүдийн хурлын бүрэн эрх**

2026-03-24

БҮРТГЭВ

СЗХ

ОН СӨР өдөр

БҮРТГЭВ

№ 01

12.1 Дараах асуудлууд нь сангийн гишүүдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн энгийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Үүнд:

- 12.1.1 Сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
- 12.1.2 Нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр санг өөрчлөн байгуулах;
- 12.1.3 Санг татан буулгаж хөрөнгө оруулагчдад хөрөнгийг хуваарилах;
- 12.1.4 Нэгж эрхийг хуваах буюу нэгтгэх;
- 12.1.5. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийг сонгох, байгуулсан гэрээг цуцлах, хуульд заасан тохиолдолд хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх, үүргийг өөр этгээдэд шилжүүлэх;
- 12.1.6. Кастодианыг сонгох, байгуулсан гэрээг цуцлах, хуульд заасан тохиолдолд хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх, үүргийг өөр этгээдэд шилжүүлэх;
- 12.1.7. Хөрөнгө оруулалтын менежментийн компани болон кастодианы төлбөр, дээд хязгаарыг тогтоох;
- 12.1.8. Хөрөнгө оруулалтын санг татан буулгах.
- 12.1.9. Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 12.1.10. Сангийн зардлын төрөл, дээд хэмжээг батлах
- 12.1.11 ТУЗ-ийн гишүүдийг сонгох, хугацаанаас нь өмнө бүрэн эрхээс нь чөлөөлөх,
- 12.1.12 ТУЗ-өөс шийдвэрлэж чадаагүй тохиолдолд их хэмжээний хэлцлийг батлах
- 12.1.13 ТУЗ-өөс шийдвэрлэж чадаагүй тохиолдолд сонирхолын зөрчилтэй хэлцлийг батлах
- 12.1.14 Хууль тогтоомжид заасан болон хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
- 12.1.15 ТУЗ-н гишүүдийг хугацаанаас өмнө дуусгавар болгохдоо энэ дүрмийн 11.4 заалт болон Компаний тухай хууль болон холбогдох бусад хуулийг үндэслэл болгоно.
- 12.2 Сангийн гишүүдийн хурал нь хууль болон хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасан ХОМК болон сангийн менежерийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрхгүй.

#### **Арвангуравдугаар зүйл.**

#### **Төлөөлөн удирдах зөвлөл ба түүний бүрэн эрх**

- 13.1 Дараах асуудлууд сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах бөгөөд хуралд оролцсон ТУЗ-ийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
  - 13.1.1 Сангийн гишүүдийн ээлжит болон ээлжит бус хурлыг ХОМК болон өөрийн саналаар зарлан хуралдуулах
  - 13.1.2 Сангийн гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх
  - 13.1.3 ХОМК-иас санал болгосон сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг батлах, өөрчлөлт оруулах;
  - 13.1.4 Сангаас холбогдох хууль тогтоомжид заасан их хэмжээний хэлцэл байгуулах ХОМК-ний шийдвэрийг батлах;
  - 13.1.5 Сангаас холбогдох хууль тогтоомжид заасан сонирхолын зөрчилтэй хэлцэл байгуулах ХОМК-ний шийдвэрийг батлах
  - 13.1.6 Хууль тогтоомжид заасан болон хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

2026-03-24

БҮРТГЭВ 02



13.2 ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байх ба сангийн гишүүдийн хурлаас ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно.

13.3 Сангийн ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгох бөгөөд ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох саналыг тус тусад нь тоолно.

13.4 Урт хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилж болно. Энэ түр орлох гишүүн нь Компанийн тухай хуульд заасан хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба түүний ТУЗ-ийн гишүүний эрхийг эдлэнэ.

13.5 ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тухайн хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.

13.6 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийг үйл ажиллагааг зохин байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

13.7 ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах ба шаардлагатай гэж ТУЗ-ийн дарга үзвэл нэмэлт хурал хийж болно. ТУЗ-ийн хурал хуралдуулах саналыг ТУЗ-ийн дарга, гишүүд, ХОМК болон сангийн менежер гаргах эрхтэй. Хурал хуралдуулах саналд хурлаар хэлэлцэх асуудлыг гаргах шийдвэрийн төслийг тусгасан байх ба уг саналыг ТУЗ-ийн даргад ирүүлнэ.

13.8 ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг үүргийг ХОМК-ийн сангийн менежер гүйцэтгэнэ.

#### Арвандөрөвдүгээр зүйл.

#### Хөрөнгө оруулалтын менежментийн компани

14.1 Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үндсэн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлэх, түүнийг төлөөлөх ажиллагаа байна.

14.2 “Би Би Эс Эй ҮЦК” ХХК нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр санд үйлчилгээ үзүүлнэ.

“Би Би Эс Эй ҮЦК” ХХК-ийн мэдээлэл:

Оноосон нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Хаяг	Холбоо барих утас
“Би Би Эс Эй ҮЦК” ХХК	РД:5472679	9011284138	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Би Ди Сек ХК-ны байр, 303 тоот	99110780 80032424

14.3 ХОМК нь санд холбогдох үйлчилгээг үзүүлэхдээ тухайн сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

#### Арвантавдугаар зүйл.

#### Сангийн менежерийн эрх, үүрэг

2026-03-24

БҮРТГЭВ



15.1 Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг ХОМК-аас томилсон сангийн менежер удирдана.

15.2 Сангийн менежер нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

15.2.1 Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

15.2.2 Сангийн хөрөнгө нь энэхүү дүрэм болон Хорооноос тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж буй талаар байнгын хяналтыг хэрэгжүүлэх;

15.2.3 Кастодианы үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэх гэрээний эрхийн хүрээнд хяналт тавих, кастодианыг өөрчлөх үйл ажиллагааг эрсдэлгүй зохион байгуулах, удирдлагаар хангах;

15.2.4 Сантай холбоотой хөрөнгийн бүхий л гүйлгээнд хяналт тавих, эрсдэлийг тооцох, нягтлан бодох бүртгэлийн баримтуудыг Кастодианд хүргүүлэх;

15.2.5 Сангийн нэгж эрхийг борлуулах Мэргэжлийн оролцогчийг сонгож гэрээ байгуулах асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдүүлэх;

15.2.6 Сангийн ТУЗ болон гишүүдийн хурлыг хуралдуулахтай холбоотой баримт бичгийг боловсруулах, хурлын нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ;

15.2.7 Сангийн хөрөнгө оруулалтын шийдвэр, Сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан журмаар гаргах;

15.2.8 Санг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага бусад этгээдийн өмнө бүрэн төлөөлөх, шүүхэд нэхэмжлэл гаргах, хариуцагчаар оролцох;

15.2.9 СЗХ-оос тогтоосон хугацаанд болон энэхүү дүрэм бусад журамд заасны дагуу Сангийн тайлан, мэдээг бусад мэдээллийг гаргаж холбогдох этгээдэд нь хүргүүлэх;

15.2.10 Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх, үүргийг хариуцан хэрэгжүүлэх;

15.2.11 Тухайн сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах.

15.3 Сангийн менежерийн шийдвэр болон үйл ажиллагааны хариуцлагыг хөрөнгө оруулалтын менежментийн компани хариуцана.

#### **Арванзургаадугаар зүйл.**

##### **Хөрөнгө оруулалтын бодлого**

16.1 Сан нь хөрөнгө оруулалтын бодлоготой байна.

16.2 Сангийн хөрөнгө оруулалтын бодлогод хөрөнгө оруулалтын зорилтуудтай холбоотой мэдээлэл, хөрөнгө оруулалтын эрсдлийг тараан байршуулах, хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийн төрөл, болон хөрөнгө оруулалт, зээл, хязгаарлалт зэргээс гадна дараах асуудлуудыг заавал тусгана. Үүнд:

16.2.1 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл;

16.2.2 Хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулалтын хэрэгслийн жагсаалт, хязгаарлалт;

16.2.3 Хөрөнгө оруулалтын сангийн активын бүтцэд тавигдах шаардлага;

#### **Арвандолоодугаар зүйл.**

##### **Кастодианы үйлчилгээ үзүүлэгч**

2026-03-24

БҮРТГЭВ



17.1 Кастодианы үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн бүртгэл, хадгалалтыг хөрөнгө оруулалтын сантай байгуулсан хөрөнгө хадгалах тухай гэрээний

үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаа байна.

17.2 Сангийн кастодианы үйл ажиллагааг Хаан банк хэрэгжүүлнэ.

17.3 Хаан банкны мэдээлэл:

Оноосон нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Хаяг	Холбоо барих утас
ХААН банк	2693321		Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион Оргил 1, Чингисийн өргөн чөлөө 6, ХААН Банк цамхаг, УБ-17010	75153333 (3420)

17.4 Кастодиан нь хөрөнгө оруулалтын санд холбогдох үйлчилгээг үзүүлэхдээ тухайн сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

#### Арваннаймдугаар зүйл.

#### Нягтлан бодох бүртгэл

18.1 Сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ХОМК баталж түүний дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлнө.

18.2 Сангийн орлого, зардлыг тооцоолохдоо хамгийн бодит байх зарчмыг баримтална. Энэхүү зарчим нь Олон улсын НББ-ын зарчимд нийцсэн, тайлагнахдаа СТОУС-ыг хангасан мөн аливаа тооцооллыг хийхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалыг ашиглан тооцоолсон байна.

18.3 Сангийн мөнгөн хөрөнгө болон сангийн актив дахь хөрөнгө оруулалтын хэрэгслийг тухайн сангийн нэр дээр нээсэн кастодианы тусгаарласан дансанд байршуулах ба түүнд кастодиан банк хяналт тавина.

18.4 Сангийн санхүүгийн тайлан тэнцэлд ханшийн тэгшитгэл болон дахин үнэлгээг өдөр бүр хийнэ. Ингэхдээ гадаад валютын хувьд Монголбанкнаас гаргадаг өдөр бүрийн ханшийн мэдээг, үнэт цаасны хувьд өмнөх өдрийн хаалтын ханшыг хэрэглэнэ.

18.5 Жилд нэг, улиралд нэг, эсвэл сар бүр, долоо хоног бүр эсвэл өдөр бүр гардаг тогтмол зардлууд эсвэл орлогын хувьд (банкны данс хөтөлсний шимтгэл, жилийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын хөлс, банкны харилцах дансны үлдэгдэлд боддог хүү, Кастодиан банкаар үйлчлүүлсний хөлс, брокерийн үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрлийн жил бүрийн хураамж, Менежментийн компанийн үйлчилгээний хөлс) цэвэр хөрөнгийн үнэлгээ хийх мөчлөгтэй үялдуулан жигд хуваарилан хуримтлуулж тооцно.

18.6 Сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийн мэдээллийг өөрийн цахим хуудас эсвэл МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан, гаргасан нийт нэгж эрхийн тоо, шинээр гаргасан болон буцаан худалдаж авсан нэгж эрхийн тоо ширхэг, хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлж буй хөрөнгө (үнэт цаасны хувьд нэр, код)-ийн нэр төрөл, тоо ширхэг зэрэг мэдээллийг өдөр бүр нийтэд мэдээлнэ.

2026-03-24

БҮРТГЭВ 03



18.7 Сангийн нийт гаргасан нэгж эрхийн 5 хувь ба түүнээс дээш хэмжээний нэгж эрх эзэмшигчдийн жагсаалтанд өөрчлөлт гарсан тухай бүр ажлын 5 хоногийн дотор МХБ-д бичгээр мэдэгдэнэ.

18.8 Сангийн цэвэр хөрөнгийн өөрчлөлт, хэрэгжсэн болон хэрэгжээгүй ашиг, алдагдлын тооцоолол, удирдлагын зардал, сангийн нэгж эрх эзэмшигчид төлсөн ногдол ашиг, сангийн хөрөнгийг бүрдүүлэх үнэт цаас болон бусад хөрөнгийн нэр, эзлэх хувь зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан сангийн үйл ажиллагааны тайланг Хөрөнгө Оруулалтын Гүйцэтгэлийг Үнэлэх Олон Улсын Стандарт (GIPS)-ын дагуу улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж, улирлын тайланг дараа сарын 10-ны дотор, хагас жилийн тайланг санхүүгийн тайлангийн хамт 7 дугаар сарын 20-ны дотор, жилийн тайланг санхүүгийн тайлангийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 31-ний дотор МХБ-д хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

#### **Арванесдүгээр зүйл.**

#### **Сангийн дотоод хяналтын бүтэц, үйл ажиллагааны журам**

- 19.1 Сангийн дотоод хяналт нь аудитын хорооны хяналт, дотоод хяналтын албаны хяналт, кастодианы хяналт гэсэн бүтэцтэй байна.
- 19.2 Аудитын хорооны хяналтыг ТУЗ нь хэрэгжүүлнэ.
- 19.3 Дотоод хяналтын албаны хяналтыг хөрөнгө оруулалтын менежментийн компанийн дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.
- 19.4 Кастодианы хяналтыг санд үйлчилгээ үзүүлэх кастодиан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т зааснаар хэрэгжүүлнэ.
- 19.5 СЗХ-оос хяналт, зохицуулалт хийнэ.

#### **Хорьдугаар зүйл.**


#### **Санг татан буулгах, алдагдал хүлээх, төлбөрийн чадваргүй болох үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

- 20.1 Дараах тохиолдолд санг татан буулгана. Үүнд:
  - 20.1.1 Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусгавар болсон;
  - 20.1.2 Сангийн гишүүдийн хурлаас тухайн санг сайн дурын үндсэн дээр хугацаанаас өмнө татан буулгахаар шийдвэрлэсэн;
  - 20.1.3 Хуульд заасны дагуу ХОМК, ТУЗ-өөс хөрөнгө оруулалтын сангийн гишүүдийн хурлыг зарлан хуралдуулсан бөгөөд сангийн гишүүд санг татан буулгах шийдвэр гаргасан;
  - 20.1.4 Хуульд заасны дагуу онцгой нөхцөл байдал үүссэн бөгөөд албадан татан буулгах шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;
  - 20.1.5 Хөрөнгө оруулалтын сан дампуурсан.
- 20.2 Санг татан буулгах шийдвэрийг дараахь этгээд гаргана. Үүнд:
  - 20.2.1 Энэхүү дүрмийн 20.1.1-20.1.3-т заасан үндэслэлээр хөрөнгө оруулалтын сангийн гишүүдийн хурал;
  - 20.2.2 Энэхүү дүрмийн 20.1.4, 20.1.5-т заасан үндэслэлээр СЗХ болон эрх бүхий бусад этгээдийн хүсэлтийг үндэслэн шүүх.
- 20.3 Санг татан буулгаж, түүнтэй холбоотой Сангийн хөрөнгийг худалдан борлуулах, төлбөр тооцоог дуусгавар болгох, үлдсэн хөрөнгийг гишүүдэд хуваарилах үйл ажиллагааг ХОМК хэрэгжүүлнэ.

1  
2026 -03- 24

БҮРТГЭВ-02

20.4 ХОМК болон Кастодианы аль алиных нь тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдолд СЗХ өөр компанийг сонгон шалгаруулж, татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх олгоно.



**Хориннэгдүгээр зүйл.**

**Татан буугдсан хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хуваарилах**

21.1 Татан буугдсан хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг нэгж эрх эзэмшигчдэд хувь тэнцүүлэн хувиарлана.

21.2 Энд дурдаагүй зүйлүүд Компаний тухай хууль, СЗХ-ны холбогдох журам, Сангийн татан буулгах үйл ажиллагааны журмаар зохицуулагдана.

**Хоринхоёрдугаар зүйл.**

**Дүрэм хүчин төгөлдөр болох,  
нэмэлт, өөрчлөлт оруулах**

22.1 Энэ дүрмийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

22.2 Энэхүү дүрэмд СЗХ-ны зөвшөөрлөөр сангийн гишүүдийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

--ooOoo--